

**Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын  
жишиг сорил-5**

Сорилын зөв хариулт

1-D, 2-D, 3-C, 4-B, 5-E, 6-C, 7-D, 8-D, 9-D, 10-D, 11-D, 12-E, 13-D, 14-D, 15-D, 16-D, 17-E, 18-C, 19-A, 20-C, 21-E, 22-E, 23-E, 24-A, 25-E, 26-E, 27-E, 28-E, 29-E, 30-A, 31-A, 32-A, 33-A, 34-B, 35-C, 36-D, 37-C, 38-D, 39-A, 40-B, 41-D, 42-C, 43-C, 44-C, 45-E, 46-C, 47-B, 48-C, 49-C, 50-D, 51-B, 52-C, 53-A, 54-C, 55-C, 56-B, 57-D, 58-B, 59-B, 60-D, 61-D, 62-C, 63-E, 64-C, 65-D, 66-B, 67-D, 68-A, 69-C, 70-B, 71-B, 72-B, 73-A, 74-B, 75-A, 76-D, 77-C, 78-C, 79-D, 80-A, 81-C, 82-B, 83-B, 84-A, 85-B, 86-A, 87-C, 88-B, 89-C, 90-A, 91-B, 92-C, 93-B, 94-B, 95-D, 96-C, 97-D, 98-D, 99-A, 100-A, 101-A, 102-D, 103-B, 104-B, 105-A, 106-B, 107-B, 108-D, 109-A, 110-A, 111-B, 112-E, 113-A, 114-A, 115-C, 116-E, 117-A, 118-C, 119-E, 120-C, 121-A, 122-C, 123-A, 124-C, 125-C, 126-E, 127-C, 128-D, 129-C, 130-A, 131-C, 132-C, 133-C, 134-E, 135-A, 136-C, 137-A, 138-C, 139-A, 140-A, 141-E, 142-A, 143-A, 144-C, 145-E, 146-A, 147-E, 148-A, 149-C, 150-A, 151-A, 152-A, 153-E, 154-A, 155-C, 156-A, 157-C, 158-C, 159-A, 160-A, 161-D, 162-A, 163-C, 164-A, 165-A, 166-A, 167-A, 168-C, 169-A, 170-C, 171-A, 172-A, 173-A, 174-A, 175-C, 176-C, 177-C, 178-A, 179-A, 180-A, 181-C, 182-A, 183-D, 184-A, 185-E, 186-D, 187-A, 188-A, 189-A, 190-A, 191-A, 192-C, 193-A, 194-A, 195-A, 196-A, 197-A, 198-C, 199-C, 200-B, 201-C, 202-C, 203-C, 204-C, 205-A, 206-E, 207-A, 208-A, 209-C, 210-B, 211-C, 212-A, 213-E, 214-E, 215-E, 216-E, 217-B, 218-E, 219-E, 220-A, 221-E, 222-B, 223-C, 224-C, 225-A, 226-B, 227-A, 228-C, 229-A, 230-E, 231-B, 232-B, 233-E, 234-E, 235-C, 236-A, 237-C, 238-D, 239-A, 240-A, 241-D, 242-A, 243-C, 244-A, 245-C, 246-C, 247-A, 248-E, 249-E, 250-B, 251-C, 252-A, 253-D, 254-D, 255-E, 256-A, 257-E, 258-A, 259-E, 260-C, 261-A, 262-A, 263-C, 264-E, 265-A, 266-B, 267-D, 268-C, 269-B, 270-C, 271-B, 272-C, 273-B, 274-B, 275-D, 276-D, 277-B, 278-B, 279-B, 280-B, 281-C, 282-B, 283-D, 284-C, 285-D, 286-C, 287-B, 288-D, 289-B, 290-C, 291-B, 292-C, 293-B, 294-D, 295-A, 296-A, 297-C, 298-B, 299-A, 300-A, 301-D, 302-B, 303-A, 304-A, 305-A, 306-E, 307-E, 308-E, 309-A, 310-C, 311-B, 312-E, 313-A, 314-E, 315-E, 316-A, 317-C, 318-E, 319-E, 320-C, 321-E, 322-E, 323-C, 324-E, 325-B, 326-B, 327-E, 328-B, 329-B, 330-C, 331-A, 332-A, 333-C, 334-A, 335-A, 336-A, 337-A, 338-B, 339-E, 340-E, 341-A, 342-E, 343-A, 344-B, 345-A, 346-E, 347-B, 348-E, 349-E, 350-E, 351-B, 352-A, 353-E, 354-A, 355-E, 356-E, 357-E, 358-B, 359-E, 360-A, 361-E, 362-E, 363-B, 364-E, 365-A, 366-A, 367-E,

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
  - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
  - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
  - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
  - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
  - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
  - Зөв, Зөв, Зөв (A.)
  - Зөв, Зөв, Буруу (B.)
  - Зөв, Буруу, Буруу (C.)
  - Буруу, Зөв, Буруу (D.)
  - Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Гуурсан хоолойн багтраа, гипервентиляци, анафилаксийн шок зэргийн үед бүгдэд нь адилхан илрэх ямар шинж байна вэ?

A. Бүгдэд нь амилуулах амьсгалуулалт хийх заалттай

- V. Зөвхөн хүүхдэд тохиолдоно
  - C. Бүгд амь тэнссэн байдлын илрэл
  - D. Бүгдэд нь амьсгалын дутагдлын шинж илэрнэ
  - E. Бүгдэд нь артерийн даралт нь буурна
- /2./ Хахаж дугарч, амьсгалж чадахгүй, ухаантай байгаа осолдогчид үзүүлэх тусламжийн удирдамжид хамаарахгүйг нь тэмдэглэнэ үү?
- A. Сээрэн дээр 5 удаа дэлсэх
  - B. Аюулхайг бүслэн шахах (5 удаа)
  - C. Дээрх ажилбарыг давтан хийх
  - D. Амилуулах амьсгалуулалт хийх
  - E. Амилуулах суурь тусламж эхлэх
- /3./ Гэмтсэн өвчтөнийг гэмтлийн байрнаас яаралтай холдуулах заалтанд хамаарахгүйг нь тэмдэглэнэ үү?
- A. Галын аюул
  - B. Угаарын хий
  - C. Цус алдах
  - D. Дэлбэрэх
  - E. Живэх
- /4./ Осолдсон хүнийг амь тэнссэн байдалд орсон эсэх үнэлгээнд хамаарахгүйг нь тэмдэглэнэ үү?
- A. Осолдогчтой харилцаж, дуудах
  - B. Ухаангүй байвал тусламж дуудах
  - C. Амьсгалын замыг чөлөөлөх
  - D. Амьсгалалтыг чагнах
  - E. Цус алдаж байгаа эсэхийг шалгах
- /5./ Амьсгалын дутагдлын эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү?
- A. Амьсгалын агаарын урсгалын чимээ шуугиж, хяхнаж сонсогдох
  - B. Айж бачимдах, хамрын угалз сарталзах, ам ангайх
  - C. Царай хөхөлбөр, баргар, хөлөрсөн
  - D. Амьсгал давчидсан, олширсон
  - E. Дээрх бигд
- /6./ Өвчтөнөөс эмчид халдвар дамжих үйл явцад хамаарахгүй хүчин зүйлийг нэрлэнэ үү?
- A. Өвчтөн халдвар үүсгэгч нян, вирустай байх
  - B. Өвчтөний цус, шингэн эмчийн биед нэвтрэх зам байх
  - C. Өвчтөн эмгэг өвчнөөр халдварлагдсан өгүүлэмж
  - D. Эмчийн биед халдвар үүсгэхүйц олон тооны нян нэвтэрч орох
  - E. Эмчийн дархлаа сул байх
- /7./ Амьсгалын дутагдалтай өвчтөн бүрт авч хэрэгжүүлдэг арга хэмжээг нь сонгоно уу?
- A. Амилуулах амьсгалуулалт хийнэ
  - B. Амны хөндийгээс соруулж цэвэрлэнэ
  - C. Өвчтөнд хүйтэн ус уулгана
  - D. Өвчтөнийг тохиромжтой (суугаа) байрлалд оруулан, амраана
  - E. Аюулхайг бүслэн шахах аргачлал
- /8./ Өвчтөн осолдон байранд тусламж үзүүлж эхлэхээс өмнө заавал гүйцэтгэх ямар үйлдэл шаардлагатай вэ?
- A. Өвчтөнийг зөв байрлуулах
  - B. Ослын гэрчээс асуух
  - C. Тусламж дуудах
  - D. Ослын орчныг үнэлэх
  - E. Анхны тусламжийн цүнхээ шалгах
- /9./ Амилуулах амьсгалуулалт зөв хийж байгааг илтгэх үзүүлэлтийг нэрлэнэ үү?
- A. Өвчтөний хацар томбойх
  - B. Өвчтөний аюулхай орчим цүрдийх
  - C. Амьсгалуултын үед өвчтөний хамраар агаар урсаж гарах
  - D. Цээж тэлж, өвчүү өргөгдөх
  - E. Хавирга завсрын булчин хонхойж сорогдох

/10./ Гэмтсэн өвчтөнийг дуудахад хариулахгүй бол дэслэлийн дагуу хэрэгжүүлэх анхны арга хэмжээг сонгоно уу?

- A. Осолдогч амь тэнссэн байдалд ороогүй байна гэж үнэлнэ
- B. Амьсгалын замыг чөлөөлнө
- C. Амсгалуулна
- D. Тусламж дуудна
- E. Цус эргэлтийн байдлыг үнэлнэ

/11./ Өвчтөн амь тэнссэн байдалд ороогүй хөнгөвтөр гэмтэл авсан үед анхааран ажиллах хамгийн чухал зүйл юу вэ?

- A. Гэмтлийн байрнаас зөөж холдуулах
- B. Ар гэрийнхэнд мэдэгдэх
- C. Ажлын газарт нь дуулгах
- D. Өвчтөний биеийн байдлыг хүндрүүлж болох гэмтлийг илрүүлж анхны тусламж үзүүлэх
- E. Ойрын эмнэлэгт тээвэрлэн хүргэх

/12./ Осолдогч хүзүүний нугалам, нурууны гэмтэлтэй байх үед ойр зуур зөөж холдуулахад ямар аргыг сонгох вэ?

- A. Нэг аврагч сугадаж
- B. Хоёр аврагч сугадаж
- C. Нэг аврагч үүрч
- D. Хоёр аврагч чагталсан гар дээр өргөх
- E. Хувцасных мөрнөөс зөөлөн чирэх

/13./ Хүүхдийн яаралтай тусламжийн үед эмнэлзүйн ямар тохиолдолд аврах амьсгалуулалтыг хийх вэ?

- A. Ухаантай, амьсгалын дутагдалтай
- B. Ухаангүй
- C. Ухаангүй, амьсгалын дутагдалтай
- D. Ухаагүй, амьсгал зогссон, судасны лугшилт тэмтрэгдэнэ
- E. Ухаагүй, амьсгал зогссон, судасны лугшилт тэмтрэгдэхгүй

/14./ Осолдогч хахах шалтгаанд хамаарахгүйг нь заана уу?

- A. Хоол идэхийн өмнө болон идэж байх үед архи уух
- B. Хоолны хатуу бүхэл хэсгийг муу зажилж залгихаар оролдох
- C. Хиймэл шүдээ залгих
- D. Ухаантай өвчтөн бөөлжих үед
- E. Амандаа хатуу зүйл хийсэн үедээ инээх, гүйх, тоглох

/15./ Өдрийн хоолны үеэр таны найз гэнэт ханиалгаж, дуу нь суларч, хяхнах чимээ сонсогдов. Та ямар тусламж үзүүлэх вэ?

A. Шалан дээр хэвтүүлээд, амыг ангайлгаж хуруугаараа гадны биетийг гогдож гаргахыг оролдоно

- B. Шалан дээр хэвтүүлээд 2 удаа амьсгалуулж, 5 удаа аюулхай дээр нь дэлсэнэ
- C. Сайн ханиалгаж, уртаар амьсгалахыг зөвлөнө
- D. Сээрэн дээр дэлсэх, аюулхайг бүслэн шахах ажилбарыг хэрэгжүүлнэ
- E. Толгойг гэдийлгэж, оочийг өргөж ажигбар хийнэ

/16./ Гэмтсэн өвчтөнөөс асууж цуглуулдаг өгүүлэмжид хамаарахгүйг нь тодруулна уу?

- A. Яаж гэмтсэн, юу тохиолдсон бэ
- B. Биеийн аль хэсэгт өвдөж, хөндүүрлэж байна вэ
- C. Харшилтай юу
- D. Архаг өвчний түүх
- E. Тогтмол хэрэглэдэг эмийн бодис

/17./ Зүрхний шигдээс өвчний эмнэлзүйн шинжүүдийг сонгоно уу?

1. Гар хөлийн үзүүр хөрөх
2. Хөлрөх
3. Цээжээр өвдөх
4. Арьс цайрах
5. Амьсгал давчдах

/18./ Хахаж, ухаан алдаж унасан осолдогчийг аврах удирдамжид заасан аргачлалыг сонгоно уу?

1. Сээрэн дээр 5 удаа дэлсэх
2. Тусламж дуудах
3. Амилуулах амьсгалуулалт хийх
4. Амилуулах суурь тусламж эхлэх
5. Аюулхайг бүслэн шахах

/19./ 82 настай элэгний хавдартай өвчтөний хүчтэй өвдөлтийг намдаахаар Морфиныг 10 мг-аар 4 цагаар уулгаж эхэлсэн боловч, өвчтөн дэмийрч, хий зүйл харж, авцалдаагүй зүйл ярьж эхэлсэн. Өвчтөнд нас барах үеийн шинж илрээгүй. Энэ өвчтөнд хэрхэн туслах вэ?

1. Настай өвчтөнд Морфины эхлэх тунг 5 мг байдаг тул Морфин уулгах тунг 5 мг болгож багасгах

2. Настай өвчтөнд Морфины метаболизм элгэнд удааширсан ба бөөрөөр ялгарах нь удааширсан байдаг тул Морфин уулгах цагийг холдуулах, 5 мг-аар хоногт 8-12 цагаар уулгах

3. Морфины хордлогыг тайлах зорилгоор физиологийн уусмал судсаар, эсвэл арьсан доор дуслаар хийх

4. Морфиныг хасах ба дахин хэрэглэхгүй байх

5. Өвчтөн нас барах гэж байгаа тул бүх эмчилгээг хасах.

/20./ Спиринолактоны (Верошпирон) шахмал хэдэн мг-тай байдаг вэ? Асциттай өвчтөнд хэдэн мг-аар уулгаж эхлэх вэ?

1. 5 мг-ын шахмал

2. 25 мг-ын шахмал

3. 1 шахмалаар уулгах

4. 100 мг-аар буюу 4 шахмалаар уулгах

5. 50 мг буюу 2 шахмалаар уулгах

/21./ Гэмтсэн өвчтөн амь тэнссэн байдалд орсон шинжүүдэд хамаарахыг нь тэмдэглэнэ үү?

1. Ухаангүй

2. Амьсгал саадтай (хяхнасан амьсгал)

3. Амьсгалын тоо хэт цөөрсөн, олширсон, давчидсан

4. Амьсгалын хөдөлгөөн ажиглагдахгүй

5. Их хэмжээний цус алдсан

/22./ Гэмтсэн өвчтөнийг шаардлаггүй үед хөдөлгөж, зөөхөд ямар сөрөг нөлөө гарч болох вэ?

1. Хугарсан яс арьсийг цоолох

2. Хугарсан яс зөөлөн эд, судас гэмтээх

3. Цус алдалтыг нэмэгдүүлэх

4. Шарханд халдвар орох

5. Өвдөлт нэмэгдүүлэх

/23./ Зүрх зогсоход хүргэдэг осол гэмтлийн үндсэн шалтгаануудыг тэмдэглэнэ үү?

1. Зам тээврийн осол

2. Живэх

3. Угаартах

4. Хордох

5. Хахах

/24./ Ослолдсон хүнд тусламж үзүүлэх явцад эмчид учирч болох ямар эрсдэл байх вэ?

1. Халдвар авах

2. Зам тээврийн осолд өртөх

3. Хорт хийгээр амьсгалах

4. Архаг эмгэг өвчин тусах

5. Хахах

/25./ Зүрхний гаралтай цээжээр өвдөх эмнэлзүйн онцлогуудыг тэмдэглэнэ үү?

1. Цээжний өвдөх + амьсгал давчдах

2. Цээжний өвдөх + дотор муухайрч, бөөлжих

3. Цээжээр өвдөх + толгой эргэх, муужрах

4. Цээжээр өвдөх + чацга алдах

5. Цээжээр өвдөх + хөлрөнө, арьс хөхрөнө, хөрнө

/26./ Осолдогчид анхны тусламж үзүүлэхдээ халдвар авахаас хамгаалах арга хэрэгслэлүүдийг нэрлэнэ үү?

1. Хамгаалалтын бээлий өмсөх
  2. Хамгаалалтын нүдний шил зүүх
  3. Бээлий өмсхөөс өмнө бөгж, бугуйвч, цагаа тайлах
  4. Амны хаалт зүүх
  5. Гарын шарх, шалбархайд тусламж үзүүлж эхлэхээс өмнө наалдамхай (шархны) тууз нааж хамгаалах
- /27./ Эдгэрэх боломжгүй шархтай өвчтөний амьдралын чанарыг дээшлүүлэхэд хэрхэн туслах вэ?
1. Шархны өвдөлтийг намдаах
  2. Шархны шүүрлийг багасгах ба үнэрийг арилгах
  3. Шархыг томруулахгүй байх ба халдвар орохоос сэргийлэх
  4. Шархнаас цус алдахаас сэргийлэх
  5. Шархны улмаас сэтгэлээр унаж, нийгмээс тусгаарлагдахгүй байхад анхаарах
- /28./ Осолдсон хүнийг амь тэнссэн байдалд орсон эсэхийг үнэлэх үзүүлэлтэнд хамаарахыг нь тэмдэглэнэ үү?
1. Осолдогчтой харилцаж, дуудах
  2. Амьсгалын замыг чөлөөлөх
  3. Амьсгалалтыг чагнах
  4. Цус алдаж байгаа эсэхийг шалгах
  5. Судасны лугшилтыг тэмтэрч үзэх
- /29./ Ерөнхий мэргэжлийн эмч амилуулах суурь тусламжаа зогсоох заалтууд
1. Тусламж үзүүлэгчид ослын орчны байдал аюултай болох
  2. Осолдогчийн амьсгалын үйл ажиллагаа сэргэх
  3. Дефибриллятортой аврах багийнхан хүрэлцэн ирэх
  4. Тусламж үзүүлэгч бүрэн цуцаж туйлдах
  5. Амилуулах тусламж үзүүлээд 30 минутаас илүү болох, хамтын шийдвэрийг үндэслэх
- /30./ Өвчтөн Б 36 настай, бөөрний архаг дутагдлын улмаас гемодиализ 28 удаа хийлгэсэн боловч одоо юу ч хийгээд нэмэргүй гээд гэрт нь гаргасан. Түүний ухаан саруул, арьс, амьсгалаас шивтэр үнэртдэг ба бие нь маш их загатнадаг. Түүний бүх бие хавантай ба түүнд дотор муухайрах бөөлжих шинж маш ихээр илэрсэн тул идэж уух сонирхолгүй болсон. Түүний бөөлжих эмгэг жамд ямар нейротрасмиторууд оролцож байгаа вэ?
1. Допамин
  2. Гистамин
  3. Серотонин
  4. Холинэрг
  5. Простогландин
- /31./ Зүрхний гаралтай цээжээр өвдөх эмнэлзүйн онцлогуудыг тэмдэглэнэ үү?
1. Өвчүү, цээжний тус газар дарж байгаа мэт
  2. Өвдөлт мөр, гарлуу дамжина
  3. Өвдөлт хүзүү, багалзуур, доод эрүүрүү дамжина
  4. Өвдөлт хавирганы завсарт зөвхөн нэг цэгт хүчтэй илэрнэ
  5. Өвдөлт амьсгал авах үед нэмэгдэнэ
- /32./ Өвчтөн Б 36 настай, бөөрний архаг дутагдлын улмаас гемодиализ 28 удаа хийлгэсэн боловч одоо юу ч хийгээд нэмэргүй гээд гэрт нь гаргасан. Түүний ухаан саруул, арьс, амьсгалаас шивтэн үнэртдэг ба бие нь маш их загатнадаг. Түүний бүх бие хавантай ба түүнд дотор муухайрах бөөлжих шинж маш ихээр илэрсэн тул идэж уух сонирхолгүй болсон. Түүний бөөлжих эмгэг жамд ямар нейротрасмиторууд оролцож байгаа вэ?
1. Допамин
  2. Гистамин
  3. Серотонин
  4. Холинэрг
  5. Простогландин
- /33./ Амин эрхтэнд хамаарахыг нь сонгоно уу?
1. Амьсгалын зам
  2. Амьсгалалт
  3. Цус эргэлт

- 4. Элэг
- 5. Бөөр

/34./ Архаг өвдөлт гэж ямар өвдөлтийг хэлдэг вэ?

- A. 14 хоногийн дотор намдсан өвдөлт
- B. 14 хоногоос удаан хэдэн сар, жилээр үргэлжилсэн өвдөлт
- C. 3 сараас удаан үргэлжилсэн өвдөлт
- D. 6 сараас дээш үргэлжилсэн өвдөлт
- E. 1 жилээс дээш үргэлжилсэн өвдөлт

/35./ Уушгины судсанд эмболи үүссэн өвчтөн амьсгаадаж, бачуурч байвал шалтгааны эсрэг ямар эмчилгээ хийх вэ?

- A. Антибиотик
- B. Хими эмчилгээ
- C. Тромболитик буюу тромб хайлуулах эмчилгээ
- D. Гуурсан хоолой тэлэх эмчилгээ
- E. Кардиотоник буюу дигоксин эмчилгээ

/36./ Хими эмчилгээний дараа бөөлжиж буй өвчтөнд ямар эмчилгээ илүү үр дүнтэй вэ?

- A. Омепразол
- B. Амитриптиллин
- C. Церукал
- D. Галоперидол
- E. Ранитидин

/37./ Нас барахын өмнө зарим өвчтөн яагаад халуурдаг вэ?

- A. Дархлаа эрс муудаж, халдвар авдаг тул
- B. Дархлаа эрс муудаж, биеийн хэвийн нянгууд үрждэг тул
- C. Уртавтар тархинд байрлах амин чухал төвүүд, тэр дотроо дулаан зохицуулгын төв үхэж

байгаа тул

- D. Халдвар тархинд орж, дулаан зохицуулгын төвийг цочроодог тул
- E. Хоруу бодисууд дулаан зохицуулгын төвийг цочроодог тул

/38./ Цэсэн суулгалтанд ямар эм илүү үр дүнтэй вэ?

- A. Левомецетин
- B. Метронидазол
- C. Ванкомицин
- D. Холестерамин
- E. Панзинорм

/39./ Хеморецептор цочирход ямар нейротрансмитор бөөлжилтийн төвд нөлөөлдөг вэ?

- A. Допамин
- B. Серотонин
- C. Гистамин
- D. Холинэрг
- E. Простогландин

/40./ Удаан үйлчилгээтэй 30 мг-ын Морфиныг 12 цагаар хоногт 2 удаа ууж байгаад өвдөлтгүй болсон өвчтөний удаан үйлчилгээтэй уудаг Морфин тасарсан тул түүнд богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг яаж өгөх вэ?

- A. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 3 шахмалаар 12 цагаар уулгах
- B. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 10 мг-аар 4 цагаар 6 удаа уулгах
- C. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 2 шахмалаар 3 удаа 8 цагаар уулгах
- D. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 2 шахмалаар 12 цагаар уулгах
- E. Богино үйлчилгээтэй 10 мг-ын Морфиныг 6 шахмалаар хоногт нэг удаа уулгах

/41./ Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөн сэтгэл зүйн хариу урвалын хэдэн шатыг туулдаг вэ?

- A. Үхлийн айдас ба сэтгэл түгших гэсэн 2 шат
- B. Бухимдал, нойргүйтэх гэсэн 2 шат
- C. Гутрах, хурдан үхэхийг хүсэх 2 шат
- D. Сэтгэл зүйн хариу урвалын 4 шатыг туулдаг
- E. Бухимдах, гутрах, илаарших гэсэн 3 шатыг туулдаг

/42./ Өтгөн хатаж буй өвчтөн 2-р шатны эмчилгээнд үр дүн өгөхгүй байвал 3-р шатанд ямар эмчилгээ хийх вэ?

- A. Сеннаг 15 мг-аар өдөрт 1-2 удаа уулгах.
- B. Сеннаг 22,5 мг-аар 6-12 цаг тутамд уулгах.
- C. Сеннаг уулгах ба Лактулозын сиропыг 15-30 мл-ээр өдөрт 1-2 удаа уулгах.
- D. Бисакодилын лааг шулуун гэдсэнд хийх.
- E. Бургуй тавих.

/43./ Морфины сульфатыг уулгасны дараа эсвэл лаагаар хэрэглэсний дараа хэзээ С тах-д хүрэх вэ?

- A. 10 минутын дараа
- B. 30 минутын дараа
- C. 1 цагийн дараа
- D. 4 цагийн дараа
- E. 6 цагийн дараа

/44./ 58 настай эрэгтэйн түрүү булчирхайн хавдар нь 5 сарын өмнө оношлогдож, хагалгаа хийлгэсэн боловч нурууны L4-L5 түвшинд үсэрхийлэл өгсөн ба нугас дарагдаж эхэлсэн тул 4 сарын өмнөөс нуруулуу үе үе хатгуулж, хутгалах мэт өвдөх болсон. Нуруу нь байнга чилж өвдөх боловч үе үе хатгуулж өвдөхөд дуу алдах, нойр алдах, хөмсгөө зангидаж ёолох болсон. Өвчтөн Трамадол ууж өвдөлтөө намдаадаг байсан боловч сүүлийн хоногуудад өвдөлт намдахаа больсон. Энэ өвчтөний өвдөлтийг Wong Baker-ийн ангиллаар ангилах.

- A. Носисептив
- B. Невропатик
- C. 7-10 -р зэрэг
- D. 4-6 –р зэрэг
- E. 1-3 –р зэрэг

/45./ Хэвтрийн цооролтын 4-р шат хэр гүн байдаг вэ?

- A. Арьсны дарагдсан хэсэг буцаж цайрдаггүй улайлт
- B. Арьсны улайсан хэсэг дээр хуруугаараа дараад авахад цайрдаг улайлт
- C. Арьсны эпидермис зулгарсан эсвэл цэврүүтсэн, өнгөж хонхор үүссэн байх
- D. Арьс ба арьсан доорх өөхөн эд хүртэл шархалсан
- E. Арьс, арьсан доорх өөхөн эд ба булчингийн хальс нэвт цоорч, булчин, яс үе мөчид хүрсэн

/46./ Өрхийн эмч морфин бичих эрхтэй юу?

- A. Эрхгүй.
- B. Эрхтэй боловч 10 ширхэгээс илүү бичихгүй.
- C. Өрхийн эмч хөнгөвчлөх эмчилгээний өвчтөнд опийн эмийг хэрэгцээтэй тунгаар нь 5 хоногийн жор даатгалаар хөнгөлттэй бичиж өгөх эрхтэй.
- D. Зөвхөн хавдрын эмч опийн эмийн жор бичих эрхтэй.
- E. Зөвхөн гэмтэл, мэс заслын эмч опийн эмийн жор бичих эрхтэй

/47./ Тимома буюу сэрээ булчирхайн хоргүй хавдартай 6 настай хүүхэд амьсгаадаж, амьсгал нь давчидаж, хэвтэх чадваргүй бачуурч, албадмал байдалтай ба суугаагаараа дэр түшиж унтаж байв. Түүнд яаж туслах вэ?

- A. Гуурсан хоолой тэлэх эмчилгээ
- B. Сэрээ булчирхайн хоргүй хавдрыг тайрч авах мэс засал хийх
- C. Антибиотик
- D. Хими, туяа эмчилгээ
- E. Тромболитик буюу тромб хайлуулах эмчилгээ

/48./ Морфиныг 4 цагаар 10 мг-р булчинд тарьж байсан бол уудаг IRMS морфинд шилжихдээ хэдээр уулгах ёстой вэ?

- A. 4 цагаар 10 мг-р уулгах
- B. 12 цагаар 30 мг-р уулгах
- C. 4 цагаар 30 мг-р уулгах
- D. 4 цагаар 15 мг-р уулгах
- E. 12 цагаар 15 мг-р уулгах.

/49./ Лактулоза ямар үйлчилгээтэй туулга вэ?

- A. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг ихэсгэдэг

- В. Баасыг гулгамтгай гөлгөр болгодог
- С. Осмос даралтаар гэдсэнд шингэнийг татдаг тул баасыг шингэрүүлдэг
- Д. Ходоодонд хөөж өтгөний хэмжээ, эзэлхүүнийг ихэсгэдэг
- Е. Өтгөний наалдамхай , зунгааралдсан чанарыг багасгадаг

/50./ 82 настай эмээгийн дунд чөмөг хугарсан тул гэмтэлд очсон байв. Түүний яс хэтэрхий сийрэг тул хадаас тогтохгүй гээд гипс тавиад буцаажээ. Тэр 2 сар гэртээ хэвтэрт маш их өвдөлттэй байсан ба памперс солих үед уйлдаг байв. Түүний өвдөлт 2 сарын турш намдаагүй ба хөлний яс байнга янгинах, хөдлөх үед хатгуулах зэргээр дуу алдам хүчтэй өвддөг, 7-9-р зэрэг гэж өөрөө шугаман үнэлгээнд хариулсан байв. Түүний өвдөлтийг намдаах туслах эм юу вэ?

- А. ҮЭСБЭ дангаараа
- В. Морфин ба ҮЭСБЭ хавсарч уулгах
- С. Трамадол уулгах
- Д. Аледронат (Осталон) ба Кальц, Д аминдэмийн хамт уулгах
- Е. Аледронат дангаар нь уулгах

/51./ Өвчтөн А 64 настай, элэгний хорт хавдартай ба хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд сул шингэн тогтоогдсон тул Спиринолактон 3 сарын турш 100 мг-аар ууж, 2 сарын турш 200 мг-аар буюу 8 шахмалаар өглөө бүр уудаг болсон. Түүний асцит нэг хэсэг буурсан байснаа одоо дахин ихсэж эхлэв. Одоо ямар арга хэмжээ авах вэ?

- А. Спиринолактоныг 200- 300 мг-аар өглөө бүр уулгах
- В. 200 мг Спиринолактоныг 40 мг Фуросемидтэй хавсарч уулгах.
- С. Фуросемид дангаар нь 40 мг-аар уулгах
- Д. Фуросемид дангаар нь 80 мг-аар уулгах
- Е. Парацентез хийх

/52./ 46 настай эрэгтэй Ж. системний өвчтэй ба үе мөчөөр маш их удаан хугацаагаар өвддөг, өглөөгүүр үе мөчний хөшингө илэрдэг байсан тул Аспирин, Индометацин, Ибупрофен удаан хугацаагаар буюу 4 сарын турш ууж байсан. Сүүлийн үед түүний ходоод их өвддөг болсон ба дурангаар ходоодны шарх илэрсэн. Түүний үе мөчний өвдөлт ҮЭСБЭ (үрэвслийн эсрэгстероид бус эмэнд) сайн дарагддаг байсан тул ҮЭСБЭ атлаа ходоодонд задардаггүй ба ходоодны салстыг гэмтээдэггүй ямар эм зөвлөж болох вэ?

- А. Дексаметазон
- В. Ибупрофен
- С. Олфен СР 100 (Диклоденк 100 мг)
- Д. Баерын Аспирин
- Е. Аспирин 100

/53./ Хорт хавдаргүй өвчтөн бифосфонатын бүлэг эмээс хэрэглэж болох уу? Ямар зорилгоор хэрэглэх вэ?

- А. Кальц, Д аминдэмийн дутагдлын улмаас яс нь сийрэгжсэн өвчтөн Аледронат буюу Осталоныг Даминдэм, Кальцийн хамт хэрэглэж болно.
- В. Зөвхөн ясны хавдартай өвчтөн бифосфонатын бүлэг эмээс хэрэглэнэ
- С. Зөвхөн хорт хавдрын гиперкальциемитэй өвчтөн бифосфонатын бүлэг эмээс хэрэглэнэ
- Д. Зөвхөн хорт хавдрын улмаас үүссэн эмгэг хугаралтай өвчтөн бифосфонатын бүлэг эмээс хэрэглэнэ.
- Е. Зөвхөн ясны өвдөлт намдаах зорилгоор бифосфонатын ыүлэг эмээс хэрэглэнэ.

/54./ Тэнцвэрийн төв цочирход ямар нейротрансмиттор бөөлжилтийн төвд нөлөөлдөг вэ?

- А. Допамин
- В. Серотонин
- С. Гистамин
- Д. Холинэрг
- Е. Простогландин

/55./ Морфиныг уух , тарихын харьцаа ямар байдаг вэ?

- А. 1:1
- В. 2:1
- С. 3:1
- Д. 1:3



Е. 1:4

/56./ Өтгөн хатаж буй өвчтөн 1-р шатны эмчилгээнд үр дүн өгөхгүй байвал 2-р шатанд ямар эмчилгээ хийх вэ?

- A. Сеннаг 15 мг-аар өдөрт 1-2 удаа уулгах.
- B. Сеннагийн тунг ихэсгэж, хэрэглэх цагийг ойртуулах.
- C. Сенна ба Лактулозын сиропыг 15-30 мл-ээр өдөрт 1-2 удаа уулгах.
- D. Бисакодилын лааг шулуун гэдсэнд хийх.
- E. Бургуй тавих.

/57./ Фентанил нь Морфиноос хэд дахин хүчтэй вэ?

- A. 2 дахин
- B. 3 дахин
- C. 10 дахин
- D. 100 дахин
- E. 1000 дахин

/58./ Өвчтөн С. 64 настай ходоодны хорт хавдар нь элгэнд үсэрхийлсэн ба хавдрын өвдөлтийг дарахаар Морфин уугаад 2 сар гаруй болж байгаа ба сүүлийн үед хэвлийгээр базлуулж өвддөг болсон. Тэр маш их турж эцсэн тул хоногийн ихэнхи цагийг хэвтэрт өнгөрүүлдэг. Өөрөө босоод бие засах чадваргүй. Түүний баас хатаад, гаралгүй 18 хонож байгаа. Түүний дотор нь муухайрч эвгүй үнэртэй хүрэн ногоон зүйлээр бөөлждөг болсон тул хоол идэхээ больсон. Сүүлийн 4 хоног хоол идээгүй. Хэвлийг рентгенд харахад Клойберийн аяга илэрсэн тул “Түгжрэл” гэдэг оноштой мэс заслын эмчид хандсан. Мэс заслын эмч хагалгаа даахгүй гээд буцаасан. Өвчтөн юм идэхгүй байгаа хэрнээ юугаар бөөлжиж байгаа вэ?

- A. Баасаар
- B. Ходоод, нойр булчирхай, 12 гэдэсний шүүрлээр
- C. Бүдүүн гэдсэнд хатсан баас түгжирсэн тул буцаад амаар гарч байгаа
- D. Идсэн уусан хоол хүнсээрээ
- E. Шээсээр

/59./ Хорт хавдартай амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөн сэтгэлзүйн хямарлын хэдэн шатыг туулдаг вэ?

- A. Түгших, гутрах 2 шат
- B. Шоконд орох, бухимдах, дасан зохицолт хямрах, тавилангаа хүлээн зөвшөөрөх гэсэн 4 шат
- C. Бухимдах, түгших, гутрах 3 шат
- D. Өвчнөө үгүйсгэж, оношоо бататгахыг оролдох, өөр эмч домч хайх бухимдлын шат

/60./ Амьдралын төгсгөлийн шатанд буй зайлшгүй үхэлд хүргэх өвчин туссан хүнийг сэтгэцийн аль шатанд хурдан оруулах нь чухал вэ ?

- A. I үе шат. Шоконд орох ба өвчнөө үгүйсгэх
- B. II үе шат. Бухимдах
- C. III үе шат. Дасан зохицолт хямрах
- D. IV үе шат. Тавилангаа хүлээн зөвшөөрөх ба эвлэрэх
- E. Гутрах

/61./ Хэвтрийн цооролтын 3-р шат хэр гүн байдаг вэ?

- A. Арьсны дарагдсан хэсэг буцаж цайрдаггүй улайлт
- B. Арьсны улайсан хэсэг дээр хуруугаараа дараад авахад цайрдаг улайлт
- C. Арьсны эпидермис зулгарсан эсвэл цэврүүтсэн, өнгөц хонхор үүссэн байх
- D. Арьс ба арьсан доорх өөхөн эд хүртэл шархалсан
- E. Арьс, арьсан доорх өөхөн эд ба булчингийн хальс нэвт цоорч, булчин, яс үе мөчид хүрнэ

/62./ Өмөнтэй өвчтөний өвдөлтийг намдаах гурав дах шатанд ямар эмчилгээ хийх вэ?

- A. Өвдөлт намдаах стероид бус эмүүд /аспирин, анальгин, бруфен, индометацин/
- B. Зөөлөн өвдөлт намдаах хар тамхины бэлдмэл /кодеин, трамадол/, туслах эмийг шаардлагатай бол хавсаргана
- C. Хүчтэй өвдөлт намдаах опийн бэлдмэл /морфин /, стероид бус өвдөлт намдаах эм, туслах эмийг шаардлагатай бол хавсаргана
- D. Туслах эмийг хэрэглэнэ

- Е. Тайвшруулах эмчилгээ хамгийн чухал
- /63./ Өвчтөн А 64 настай, элэгний хорт хавдартай ба хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд сул шингэн тогтоогдсон тул Спиринолактон 3 сарын турш 100 мг-аар ууж, 2 сарын турш 200 мг-аар буюу 8 шахмалаар ууж, сүүлийн сар 80 мг Фуросемидтэй хавсарч уудаг байсан. Түүний асцит нэг хэсэг буурсан байснаа одоо дахин ихсэж эхлэв. Одоо ямар арга хэмжээ авах вэ?
- А. Спиринолактоныг дагаар нь 200- 300 мг-аар өглөө бүр уулгах
  - В. 200 мг Спиринолактоныг 80 мг Фуросемидтэй хавсарч уулгах.
  - С. Фуросемид дагаар нь 40 мг-аар уулгах
  - Д. Фуросемид дангаар нь 80 мг-аар уулгах
  - Е. Өвчтөнд зовиур ихтэй ба зөвшөөрч байвал парацентез хийх
- /64./ Хиосцин бөөлжилтийн эсрэг ямар үйлчилгээтэй вэ?
- А. Хеморецепторт үйлчилдэг тул бөөлжилтийг намдаадаг
  - В. Ходоод, 12 хуруу гэдсийг доош нь гөрвөлзүүлдэг гастрокинетик үйлчилгээтэй
  - С. Бөөлжилтийн төвийг дарангуйлах үйлчилгээтэй
  - Д. Тэнцвэрийн төвийг дарангуйлах үйлчилгээтэй
  - Е. Ходоодны салстыг хамгаалах үйлчилгээтэй
- /65./ Опиоид эмийг удаан хугацаанд хэрэглэхэд үүсч болох гаж үйлчилгээг нэрлэх:
- А. Дотор муухайрах, боолжих
  - В. Унтаархах
  - С. Дэмийрэх
  - Д. Өтгөн хатах
  - Е. Амьсгал дарангуйлах
- /66./ Хөхний хавдартай өвчтөний үнхэлцгэнд шингэн хуримтлагдсан ба амьсгаадаж, амьсгал давчидаж, арьс нь хөхөрч, албадмал байдалтай сууж байвал түүний амьсгаадалтын шалтгааныг яаж эмчлэх вэ?
- А. Гуурсан хоолой тэлэх эмчилгээ
  - В. Үнхэлцгэнд хатгалт хийж шингэнийг соруулах
  - С. Антибиотик
  - Д. Хими, туяа эмчилгээ
  - Е. Тромболитик буюу тромб хайлуулах эмчилгээ
- /67./ Трамадолын жорыг ямар эмч бичих эрхтэй вэ?
- А. Опийн эм тул хавдрын, мэс заслын, гэмтлийн эмч бичнэ.
  - В. Опийн эм тул зөвхөн хавдрын эмч хортой эмийн жорын маягт нь дээр бичнэ.
  - С. Опийн эм тул хавдрын ба хөнгөвчлөх эмчилгээний эмч бичнэ.
  - Д. Ямар ч мэргэжлийн эмч энгийн жорын маягтан дээр бичнэ.
  - Е. Ямар ч мэргэжлийн эмч хортой эмийн жорын маягтан дээр бичнэ.
- /68./ Wong Baker-ийн ангиллаар дунд зэргийн өвдөлтийг ямар эмээр намдаах вэ?
- А. Трамадол
  - В. Морфин
  - С. Ибупрофен
  - Д. Диклоденк
  - Е. Долфорин
- /69./ Өвчтөн А. 72 настай, бөөрний архаг үрэвсэлтэй ба үе үе ампициллин, амоксициллин, цефазолин, ципрофлоксацин уудаг. Гэтэл үмхий үнэртэй, салсархаг, хөөсөрхөг, заримдаа цусан судалтай суулгаж эхэлсэн ба хэвлийгээр бага зэрэг өвдөх шинж илэрч, энэ нь 10 хоногоос удаан үргэлжилсэн. Тэр ямар шалтгаантай суулгалт вэ?
- А. Дизентери буюу Клебсиеллын шалтгаантай
  - В. Стафилококкийн шалтгаантай
  - С. Clostridium difficile –ийн шалтгаантай
  - Д. Escherichia coli шалтгаантай
  - Е. Дисбактериозын шалтгаантай
- /70./ Тархины бор гадарга цочирход ямар нейротрансмитер бөөлжилтийн төвд нөлөөлдөг вэ?
- А. Допамин
  - В. Серотонин

- C. Гистамин
- D. Холинэрг
- E. Простогландин

/71./ Таагүй мэдээг хүргэх Роберт Бакмены аргын 3-р алхамд эмч яах ёстой вэ?

- A. Өрөө тасалгаа, сандал, салфетк бэлдэх.
- B. Өвчтөн өөрийн өвчний талаар юу мэдэж байгааг асууж лавлах
- C. Өвчтөн шинжилгээний хариуг тайлбарлуулж, онош, өвчний явцын талаар үнэн зөв мэдээлэл авахыг хүсч байгаа эсэхийг асууж тодруулах.
- D. Эмч нар шинжилгээний хариуг хараад юу гэж хэлж байсан талаар асууж лавлах.
- E. Өвчтөнд зориулж ус, цай эсвэл кофе бэлдэх.

/72./ Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөн ба түүний ар гэрт сэтгэл зүйн тусламж үзүүлэх хамгийн сайн арга юу вэ?

- A. Амитриптиллин уухаар зөвлөх
- B. Өвчтөн ба ар гэртэй нээлттэй ярилцлагыг цаг гарган болгоомжтой хийх, үнэн зөв мэдээллээр хангах
- C. Тайвшруулах зорилгоор валериан уулгах
- D. Өвчтөний онош ба тавиланг нууцлах
- E. Эмчилгээг зөвхөн гэр бүлийн гишүүдтэй ярилцаж хийх

/73./ Өтгөн хатаж буй өвчтөнд хийх эмийн эмчилгээний 5 шатлалын хамгийн нэгдүгээрт ямар эмчилгээ заавал хийгдэх ёстой вэ?

- A. Сеннаг 15 мг-аар өдөрт 1-2 удаа уулгах
- B. Сеннаг 22,5 мг-аар 4-12 цаг тутамд уулгах.
- C. Бисакодилын лааг шулуун гэдсэнд хийх.
- D. Бургуй тавих.
- E. Лактулозын сиропыг 15-30 мл-ээр өдөрт 1-2 удаа уулгах.

/74./ 82 настай эмээгийн дунд чөмөг хугарсан тул гэмтэлд очсон байв. Түүний яс хэтэрхий сийрэг тул хадаас тогтохгүй гээд гипс тавиад буцаажээ. Тэр 2 сар гэртээ хэвтэрт маш их өвдөлттэй байсан ба памперс солих үед уйлдаг байв. Түүний өвдөлт 2 сарын турш намдаагүй ба хөлний яс байнга янгинах, хөдлөх үед хатгуулах зэргээр дуу алдам хүчтэй өвддөг, 7-9-р зэрэг гэж өөрөө шугаман үнэлгээнд хариулсан байв. Түүний өвдөлтийг намдаах үндсэн эмүүд юу вэ?

- A. ҮЭСБЭ дангаараа
- B. Морфин ба ҮЭСБЭ хавсарч уулгах
- C. Трамадол уулгах
- D. Аледронат (Осталон) ба Кальц, Д аминдэмийн хамт уулгах
- E. Аледронат дангаар нь уулгах

/75./ Өвчтөн А 64 настай, элэгний хорт хавдартай ба хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд сул шингэн тогтоогдсон тул Спиронолактон 3 сарын турш 100 мг-аар ууж, одоо 200 мг-аар буюу 8 шахмалаар өглөө бүр уудаг болсон. Түүний хэвлийн тойрог 72 цагийн дараа үзэхэд 3 см-ээр буурсан байв. Одоо ямар арга хэмжээ авах вэ?

- A. Эмчилгээг үргэлжлүүлэх ба Спиронолактоныг 200- 300 мг-аар өглөө бүр уулгах
- B. 200 мг Спиронолактоныг 40 мг Фуросемидтэй хавсарч уулгах
- C. Фуросемид 40 мг-аар уулгах
- D. Фуросемид 80 мг-аар уулгах
- E. Парацентез хийх

/76./ Хивэг ямар үйлчилгээтэй туулга вэ?

- A. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг ихэсгэдэг
- B. Баасыг гулгамтгай гөлгөр болгодог
- C. Осмос даралтаар гэдсэнд шингэнийг татдаг тул баасыг шингэрүүлдэг
- D. Ходоодонд хөөж өтгөний хэмжээ, эзэлхүүнийг ихэсгэдэг
- E. Өтгөний наалдамхай, зунгааралдсан чанарыг багасгадаг

/77./ Долфорины үйлчилгээ тууз нааснаас хойш хэзээ дээд хэмжээнд илрэх ба С мах-д хүрэх вэ?

- A. 1 цагийн дараа
- B. 6 цагийн

- C. 12 цагийн дараа
- D. 30 минутын дараа
- E. 48 цагийн дараа

/78./ Өвчтөн С. 64 настай ходоодны хорт хавдар нь элгэнд үсэрхийлсэн ба хавдрын өвдөлтийг дарахаар Морфин уугаад сар гаруй болж байгаа ба одоогоор өвдөлтгүй байгаа. Тэр ходоод орчмын өвдөлтөөс болж маш зөөлөн зутан, бантан, таташ, нухаш маягийн хоол иддэг. Тэр их турж эцсэн тул хоногийн ихэнхи цагийг хэвтэрт өнгөрүүлдэг. Өөрөө босоод бие засах чадвартай. Түүний баас хатаад, гаралгүй 10 хонож байгаа. Сүүлийн хоногуудад дотор нь муухайрч эвгүй үнэртэй хүрэн ногоон зүйлээр бөөлждөг болсон. Түүний гэдэс түгжирсэн эсэхийг яаж мэдэх вэ?

- A. Баас шиг хүрэн ногоон зүйлээр бөөлжиж байгаа нь түгжрэлийн шинж
- B. 10 хоног баагаагүй тул түгжирсэн
- C. Ердийн рентген шинжилгээгээр хэвлийг харах ба Клойберийн аяга байгаа эсэхийг тогтоох
- D. Тодруулагч бодистой хэвлийн рентген зураг авах
- E. Урографин судсаар тарьсны дараа, хэвлийн рентген зураг авах

/79./ Өрхийн эмч уудаг Морфиныг хавдрын бус өвчтөнд бичихдээ эрүүл мэндийн даатгалаар хэдэн хувиар хөнгөлөх эрхтэй вэ?

- A. 10-20%
- B. 20-30%
- C. 30-40%
- D. 50-53%
- E. 100%

/80./ Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөнд сэтгэл зүйн хариу урвалын 1-р шатанд ямар шинжүүд илрэх вэ?

- A. Шокт орох ба өвчнөө үгүйсгэх
- B. Бухимдах
- C. Дасан зохицолт хямрах
- D. Өвчнөө хүлээн зөвшөөрөх ба эвлэрэх
- E. Гутрах

/81./ Хэвтрийн цооролтын 2-р шат хэр гүн байдаг вэ?

- A. Арьсны дарагдсан хэсэг буцаж цайрдаггүй улайлт буюу улайсан хэсэг дээр хуруугаараа дараад авахад цайрдаггүй улайлт
- B. Арьсны улайсан хэсэг дээр хуруугаараа дараад авахад цайрдаг улайлт
- C. Арьсны эпидермис зулгарсан эсвэл цэврүүтсэн, өнгөц хонхор үүссэн байх
- D. Арьс ба арьсан доорх өөхөн эд хүртэл шархалсан
- E. Арьс, арьсан доорх өөхөн эд ба булчингийн хальс нэвт цоорч, булчин, яс үе мөчид хүрнэ

/82./ Өмөнтэй өвчтөний өвдөлтийг намдаах хоёр дахь шатанд ямар эмчилгээ хийх вэ?

- A. Өвдөлт намдаах стероид бус эмүүд /аспирин, анальгин, бруфен, индометацин/, туслах эмийг шаардлагатай бол хавсаргана
- B. Зөөлөн өвдөлт намдаах хар тамхины бэлдмэл /кодеин, трамадол/, туслах эмийг шаардлагатай бол хавсаргана
- C. Хүчтэй өвдөлт намдаах хар тамхины бэлдмэл /морфин, метадон, петидин/
- D. Туслах эмийг хэрэглэнэ
- E. Тайвшруулах эмчилгээ хамгийн чухал

/83./ Өвчтөн А 64 настай, элэгний хорт хавдартай ба хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд сул шингэн тогтоогдсон тул Спиринолактон 3 сарын турш 100 мг-аар ууж, 2 сарын турш 200 мг-аар буюу 8 шахмалаар ууж, сүүлийн сар 40 мг Фуросемидтэй хавсарч уудаг байсан. Түүний асцит нэг хэсэг буурсан байснаа одоо дахин ихсэж эхлэв. Одоо ямар арга хэмжээ авах вэ?

- A. Спиринолактоныг дагаар нь 200- 300 мг-аар өглөө бүр уулгах
- B. 200 мг Спиринолактоныг 80 мг Фуросемидтэй хавсарч уулгах.
- C. Фуросемид дагаар нь 40 мг-аар уулгах
- D. Фуросемид дангаар нь 80 мг-аар уулгах
- E. Парацентез хийх

- /84./ Галоперидол бөөлжилтийн эсрэг ямар үйлчилгээтэй вэ?  
A. Хеморецепторт үйлчилдэг тул бөөлжилтийг намдаадаг  
B. Ходоод, 12 хуруу гэдсийг доош нь гөрвөлзүүлдэг гастрокинетик үйлчилгээтэй  
C. Бөөлжилтийн төвийг дарангуйлах үйлчилгээтэй  
D. Тэнцвэрийн төвийг дарангуйлах үйлчилгээтэй  
E. Ходоодны салстыг хамгаалах үйлчилгээтэй
- /85./ Морфиныг арьсан доор эсвэл булчинд тарьсны дараа хэзээ C тах-д хүрэх вэ?  
A. 10 минутын дараа  
B. 30 минутын дараа  
C. 1 цагийн дараа  
D. 4 цагийн дараа  
E. 6 цагийн дараа
- /86./ Wong Baker-ийн ангиллаар ямар өвдөлтийг Морфин намдаадаг вэ?  
A. Хүчтэй буюу 7-10-р зэргийн өвдөлт  
B. Дунд зэрэг буюу 4-6-р зэргийн өвдөлт  
C. Сул буюу 1-3-р зэргийн өвдөлт  
D. Невропатик  
E. Носисептив
- /87./ Лактулоза хэдэн цагийн дараа үйлчлэх ёстой вэ?  
A. C тах нь 2 цаг тул 2 цагийн дараа  
B. C тах нь 4-6 цаг тул 6 цагийн дараа  
C. C тах нь 12-24 цаг тул 12-24 цагийн дараа  
D. C тах нь 24-32 цаг тул 24-32 цагийн дараа  
E. C тах нь 2-3 хоног тул 2-3 хоногийн дараа
- /88./ Ходоодны хавдартай өвчтөн ходоодноос их хэмжээний цус алдсан, цусны гемоглобин 50 г/л болсон ба өвчтөн амьсгаадаж, бачуурч байгаа тул шалтгааны эсрэг ямар эмчилгээ хийх вэ?  
A. Гуурсан хоолой тэлэх эмчилгээ  
B. Цус хийх  
C. Антибиотик  
D. Хими, туяа эмчилгээ  
E. Тромболитик буюу тромб хайлуулах эмчилгээ
- /89./ Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөн удаан хугацаагаар хүчил төрөгч хэрэглэх шаардлагатай бол хүчилтөрөгчийг юугаар өгөх нь дээр вэ?  
A. Амбугаар  
B. Маскаар  
C. Хамрын гуурсаар  
D. Ам амаар  
E. Ам хамраар
- /90./ Таагүй мэдээг хүргэх Роберт Бакмены арга хэдэн алхамтай вэ?  
A. 6 алхам  
B. 5 алхам  
C. 4 алхам  
D. 3 алхам  
E. 2 алхам
- /91./ 4 цагаар морфин сульфат ууж буй өвчтөнийг шөнө 2 цагт сэрээж эм уулгахгүй байх боломж бий юу?  
A. ДЭМБ-ын зөвлөсний дагуу цагийг хатуу барьж 4 цагаар уулгана.  
B. Боломж бий: өдөр 4 цагаар уулгаж байгаад шөнө 22 цагт морфины тунг 50-100% ихэсгэн өгөхөд өглөө 6 цаг хүртэл сэрэхгүй маш сайн унтуулдаг.  
C. Шөнө 2 цагт сэрээж эмийг уулгахгүй бол өвдөлт үүрээр дахих болно.  
D. Өвчтөн өөрөө 2 цагт сэрэхгүй унтаад байвал эмийг нь өгөхгүй байж болно.  
E. Шөнө сэрсэн цагт нь эмийг нь уулгаж болно.
- /92./ Зүүн хөхний хавдартай 45 настай эмэгтэйн хөхийг 2 сарын өмнө тайрсан ба суганы булчирхайг нь түүсэн, 14 хоногийн өмнөөс туяа эмчилгээнд явуулсан. Түүний хавдрын маркер буурсан боловч, сүүлийн цацраг эмчилгээний дараа зүүн гар хөдлөх болгонд

жирвэгнэх, цахилгаан гүйх мэт өвдөх болсон. Цацраг эмчилгээг зүүн хөхний оромт ба зүүн суганд хийсэн байв. Тэр өвдөлтөө 4-6-р зэрэг гэж үнэлсэн. Түүний өвдөлтийн шалтгааныг ангилна уу:

- A. Хагалгааны дараах өвдөлт
- B. Хими эмчилгээний дараах өвдөлт
- C. Цацраг эмчилгээ нь мөрний мэдрэлийг гэмтээснээс үүссэн өвдөлт
- D. Хөхний хорт хавдрын өвдөлт
- E. Хавдрын үсэрхийллийн өвдөлт

/93./ Өвчтөн А 64 настай, элэгний хорт хавдартай ба хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд 3 литр орчим сул шингэн тогтоогдсон. Түүнд одоогоор амьсгаадах, өвдөх шинж илрээгүй байна. Түүнд 100 мг-аар Спиринолактоныг өглөө бүр уулгаж эхэлсэн. 2 сарын турш асцит багасаад бараг бараг байхгүй болсон байсан боловч 3 дах сараас хэвлийд дахин шингэн хуралдаж эхэлсэн. Одоо ямар арга хэмжээ авах вэ?

- A. Эмчилгээг үргэлжлүүлэх
- B. Спиринолактоныг 200- 300 мг-аар өглөө бүр уулгах
- C. Фуросемид 40 мг-аар уулгах
- D. Фуросемид 80 мг-аар уулгах
- E. Парацентез хийх

/94./ Ургамлын тос ямар үйлчилгээтэй туулга вэ?

- A. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг ихэсгэдэг
- B. Баасыг гулгамтгай, гөлгөр болгодог
- C. Осмос даралтаар гэдсэнд шингэнийг татдаг тул баасыг шингэрүүлдэг
- D. Ходоодонд хөөж өтгөний хэмжээ, эзэлхүүнийг ихэсгэдэг
- E. Өтгөний наалдамхай, зунгааралдсан чанарыг багасгадаг

/95./ Долфорин буюу Фентанилын наалт нь хэдэн цаг өвдөлт намдаадаг вэ?

- A. 6 цаг
- B. 12 цаг
- C. 24 цаг
- D. 72 цаг
- E. 7 хоног

/96./ Тэнэгч мэдрэл цочирход өвчтөн яагаад бөөлждөг вэ?

- A. Допамин бөөлжилтийн төвд нөлөөлдөг
- B. Серотонин бөөлжилтийн төвд нөлөөлдөг
- C. Ходоод дээш сөрж агшидаг
- D. Гистамин бөөлжилтийн төвд нөлөөлдөг
- E. Бөөлжилтийн төв шууд цочирдог

/97./ Морфиныг 1% 1 мл тун шилээр 6 цаг тутам тариулж өвдөлтгүй байсан өвчтөнийг удаан үйлчилгээтэй уудаг Морфинд оруулах.

- A. Удаан үйлчилгээтэй 30 мг Морфиныг 1 шахмалаар 6 цагаар уулгах.
- B. Удаан үйлчилгээтэй 30 мг-ын Морфиныг 1 шахмалаар 8 цагаар уулгах
- C. Удаан үйлчилгээтэй 30 мг-ын Морфиныг 1 шахмалаар 12 цагаар уулгах
- D. Удаан үйлчилгээтэй 30 мг-ын Морфиныг 2 шахмалаар буюу 60 мг-аар 12 цагаар бүтнээр залгиулж уулгах
- E. Удаан үйлчилгээтэй 30 мг-ын Морфиныг 3 шахмалаар буюу 90 мг-аар 8 цагаар бүтнээр залгиулж уулгах

/98./ Өтгөн хатаж буй өвчтөн 4-р шатны эмчилгээнд үр дүн өгөхгүй байвал 5-р шатанд ямар эмчилгээ хийх вэ?

- A. Сеннаг 15 мг-аар өдөрт 1-2 удаа уулгах.
- B. Сеннаг 22,5 мг-аар 6-12 цаг тутамд уулгах.
- C. Сеннаг уулгах ба Лактулозын сиропыг 15-30 мл-ээр өдөрт 1-2 удаа уулгах.
- D. Бисакодилын лааг шулуун гэдсэнд хийх эсвэл шулуун гэдэс бургуйдах.
- E. Магнийн гидроксид, лактулозагийн тосон эмульсийг уулгах.

/99./ Морфиныг судсанд тарьсаны дараа хэзээ С тах-д хүрэх вэ?

- A. 10 минутын дараа
- B. 30 минутын дараа

- C. 1 цагийн дараа
- D. 4 цагийн дараа
- E. 6 цагийн дараа

/100./ Хэвтрийн цооролтын 1-р шатанд ямар шинж илэрдэг вэ?

- A. Арьсны дарагдсан хэсэг буцаж цайрдаггүй улайлт буюу улайсан хэсэг дээр хуруугаараа дараад авахад цайрдаггүй улайлт
- B. Арьсны улайсан хэсэг дээр хуруугаараа дараад авахад цайрдаг улайлт
- C. Арьсны эпидермис зулгарсан эсвэл цэврүүтсэн, өнгөц хонхор үүссэн байх
- D. Арьс ба арьсан доорх өөхөн эд хүртэл шархалсан
- E. Арьс, арьсан доорх өөхөн эд ба булчингийн хальс нэвт цоорч, булчин, яс үе мөчид хүрнэ

/101./ Өмөнтэй өвчтөний өвдөлтийг намдаах эхний шатанд ямар эмчилгээ хийх вэ?

- A. Өвдөлт намдаах стероид бус эмүүд /аспирин, анальгин, бруфен, индометацин/, туслах эмийг шаардлагатай бол хавсаргана
- B. Зөөлөн өвдөлт намдаах хар тамхины бэлдмэл /кодеин, трамадол/
- C. Хүчтэй өвдөлт намдаах хар тамхины бэлдмэл /морфин, метадон, петидин/
- D. Туслах эмийг хэрэглэнэ
- E. Тайвшруулах эмчилгээ хамгийн чухал

/102./ 58 настай эрэгтэйн түрүү булчирхайн хавдар нь 5 сарын өмнө оношлогдож, хагалгаа хийлгэсэн боловч нурууны L4-L5 түвшинд үсэрхийлэл өгсөн ба нугас дарагдаж эхэлсэн тул 4 сарын өмнөөс нуруулуу үе үе хатгуулж, хутгалах мэт өвдөх болсон. Нуруу нь байнга чилж өвдөх боловч үе үе хатгуулж өвдөхөд дуу алдах, нойр алдах, хөмсгөө зангидаж ёолох болсон. Өвчтөн Трамадол ууж өвдөлтөө намдаадаг байсан боловч сүүлийн хоногуудад өвдөлт намдахаа больсон. Энэ өвчтөний өвдөлтийг намдаах үндсэн эм нь юу вэ?

- A. Диклоденк
- B. Трамадол
- C. Кодеин
- D. Морфин
- E. Паракоденк

/103./ Ямар туулга зөвхөн бүдүүн гэдсийг гүрвэлзүүлдэг вэ?

- A. Докузат
- B. Сенна
- C. Бисакодил
- D. Лактулоза
- E. Хивэг

/104./ Зүрхний төрөлхийн гажигтай ба зүрхний архаг дутагдалтай өвчтөн амьсгаадаж, бачуурч байвал шалтгааны эсрэг ямар эмчилгээ хийх вэ?

- A. Гуурсан хоолой тэлэх эмчилгээ
- B. Дигоксин, панагин, фуросемид
- C. Антибиотик
- D. Хими эмчилгээ
- E. Тромболитик буюу тромб хайлуулах эмчилгээ

/105./ Залгих чадвартай боловч өөрөө халбагдах чадваргүй хүнийг яаж хооллох хэрэгтэй вэ?

- A. Халбагаар ойр ойрхон чанар шим тэжээл сайтай, хоногийн хэрэгцээг хангах чадвартай хоолыг идүүлнэ.
- B. Халбагаар бага багаар шөл, хярам зэргийг уулгаж тэжээх.
- C. Хаймсуураар байнга шингэн атлаа шим тэжээл сайтай, хоногийн хэрэгцээ хангах хоол дусааж тэжээх.
- D. Гастростомоор шингэн атлаа шим тэжээл сайтай, хоногийн хэрэгцээ хангах хоол байнга дусааж тэжээх.

/106./ Түвэнх хоолойн ургац буюу кандиломтой өвчтөн бачуурч байвал ямар арга хэмжээ авах вэ?

- A. Гуурсан хоолой тэлэх эмчилгээ
- B. Түвэнх хоолойн ургацыг мэс засал хийх авах
- C. Антибиотик
- D. Хими, туяа эмчилгээ

- Е. Тромболитик буюу тромб хайлуулах эмчилгээ
- /107./ Морфиныг 4 цагаар 20 мг-р булчинд тарьж байсан бол уудаг MS Contin-ыг ямар тунгаар яаж орлуулан өгөх вэ?
- А. 4 цагаар 20 мг-р уулгах
  - В. 12 цагаар 180 мг-р уулгах
  - С. 12 цагаар 60 мг-р уулгах
  - Д. 12 цагаар 20 мг-р уулгах
  - Е. 6 цагаар 60 мг-р уулгах
- /108./ 60 настай эмэгтэйд умайн хүзүүний хорт хавдар 2 сарын өмнө оношлогдож, мэс засал, хими, туяа эмчилгээ хийлгэсэн ба эмчилгээнд үр дүн сайн өгсөн боловч Herpes Zoster-ийн халдвар авч, биеэр нь олон цэврүүт тууралт гарсан ба маш их өвдөлттэй байсан. Тууралт арилаад сар болж байгаа боловч арьсны өвдөлт намдахгүй сар гаруй зовоож байв. Түүний өвдөлт нь хэвлий, бүсэлхийн арьсанд өнгөц хүрэхэд үүсдэг ба олон жижиг зүүгээр шивэх мэт өвддөг, өвдөлтийг 4-6-р зэрэг гэж өвчтөн өөрөө үнэлсэн байв. Өвчтөний өвдөлтийг шалтгаанаар нь ангилна уу:
- А. Умайн хүзүүний хорт хавдрын шалтгаантай
  - В. Туяа эмчилгээний шалтгаантай
  - С. Хими эмчилгээний шалтгаантай
  - Д. Herpes Zoster-ийн невралгийн шалтгаантай
  - Е. Мэс заслын дараах өвдөлт
- /109./ Өвчтөн А 64 настай, элэгний хорт хавдартай ба хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд 3 литр орчим сул шингэн тогтоогдсон. Түүнд одоогоор амьсгаадах, өвдөх шинж илрээгүй байна. Түүнд 100 мг-аар Спиринолактоныг өглөө бүр уулгаж эхэлсэн. 72 цагийн дараа хэвлийн тойргийг хэмжиж үзэхэд хэвлийн тойрог 108 см байсан бол 72 цагийн дараа 104 см болсон байв. Цаашид энэ өвчтөнд ямар арга хэмжээ авах вэ?
- А. Эмчилгээг үргэлжлүүлэх
  - В. Спиринолактоныг 300 мг-аар уулгах
  - С. Фуросемид 40 мг-аар уулгах
  - Д. Фуросемид 80 мг-аар уулгах
  - Е. Парацентез хийх
- /110./ Бисакодил ямар үйлчилгээтэй туулга вэ?
- А. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг ихэсгэдэг
  - В. Баасыг гулгамтгай гөлгөр болгодог
  - С. Осмос даралтаар гэдсэнд шингэнийг татдаг тул баасыг шингэрүүлдэг
  - Д. Ходоодонд хөөж өтгөний хэмжээ, эзэлхүүнийг ихэсгэдэг
  - Е. Өтгөний наалдамхай, зунгааралдсан чанарыг багасгадаг
- /111./ 82 настай эмээгийн дунд чөмөг хугарсан тул гэмтэлд очсон байв. Түүний яс хэтэрхий сийрэг тул хадаас тогтохгүй гээд гипс тавиад буцаажээ. Тэр 2 сар гэртээ хэвтэрт маш их өвдөлттэй байсан ба памперс солих үед уйлдаг байв. Түүний өвдөлт 2 сарын турш намдаагүй ба хөлний яс байнга янгинах, хөдлөх үед хатгуулах зэргээр дуу алдам хүчтэй өвддөг, 7-9-р зэрэг гэж өөрөө шугаман үнэлгээнд хариулсан байв. Энэ эмээд олон эм уулгахгүйн тулд орлуулаж өгөх 3-р шатны хүчтэй эм Монголд бий юу?
- А. Тариагаар Морфин хийх нь 3 дахин илүү хүчтэй
  - В. Фентанилын наалтыг (Долфорин 25 мкг/ цагт туузыг) арьсан дээр наах боломжтой
  - С. Трамадол тариагаар хийх нь илүү хүчтэй
  - Д. Паракоденк уулгах нь Морфиноос хүчтэй
  - Е. Монголд Морфиноос хүчтэй опиоид эм байхгүй
- /112./ Герпес вирусийн халдварыг дараахь байдлаар ангилдаг:
1. Анхдагч
  2. Дахилтат
  3. Түгмэл хэлбэр
  4. Байршмал хэлбэр
  5. Хавсарсан герпес
- /113./ Цочмог цусан суулгын үед эмгэг анатомын ямар өөрчлөлт гарч болох вэ?
1. Салст бүрхүүл улайж үрэвссэн



2. Фибринт өнгөр
  3. Шархлаа үүссэн
  4. Салст бүрхүүл үхэжсэн, цоорсон
  5. Цус алдсан байна
- /114./ Менингокийн мэнэнгийн үед нугасны усанд зонхилон илрэх өөрчлөлтүүдийг тэмдэглэ.
1. Даралт ихсэх
  2. Булингартай болох
  3. Уураг нэмэгдэх
  4. Эсийн тоо цөөрөх
  5. Тунгалаг эс зонхилон нэмэгдэх
- /115./ Герпес вирусын халдвараас сэргийлэх өвөрмөц арга нь аль вэ?
1. Анатоксин
  2. Иммуноглобулин
  3. Антибиотик
  4. Нийлмэл вакцин
  5. Вирусийн эсрэг бэлдмэлүүд
- /116./ Цусан суулга өвчин нэг хүртлэх насны хүүхдэд ямар онцлогтой илэрдэг вэ?
1. 1. Өтгөн ус ихтэй, усгүйжилтэнд амархан орно
  2. 2. Өтгөн салс ихтэй
  3. 3. Бүдүүн гэдэсний үрэвслийн шинж бүдэг илэрсэн
  4. 4. Дисбактериоз болох нь амархан
  5. 5. Бөгсний амсар онгойно
- /117./ Гепатитын В вирусийн халдварыг дамжуулж болох хүчин зүйлийг тэмдэглэ.
1. Цус
  2. Зүү тариур
  3. Үрийн шингэн
  4. Бохир гар
  5. Ахуйн хавьтал
- /118./ Парагриппийн халдварын үеийн эмнэлзүйн шинжүүдийг тэмдэглэ.
1. Бүх булчингаар өвдөх
  2. Толгой өвдөх
  3. Нүдний алим өвдөх
  4. Хоолой сөөх
  5. Шингэн нус их гоожих
- /119./ Тархины цочмог хаван үүссэх үндсэн шалтгаан нь:
1. Тархины цусан хангамжийн хямрал
  2. Нугасны усны хөдөлгөөн алдагдах
  3. Тархины эдийн хүчилтөрөгчийн дутал
  4. Тархины хордлого
  5. Тархины бодисын солилцооны хямрал
- /120./ Гепатитын С болон Д вирусийн халдвар дамжиж болох замуудыг сонго.
1. Агаар дусал
  2. Бэлгийн зам
  3. Хоол боловсруулах
  4. Арьс салстын шархаар
  5. Шавьж ба дамжуулагч
- /121./ Ёлом өвчний эмнэл зүйн ангилалд хамаатай асуудлыг доорхи хариултаас тохируулан сонго.
1. Эритематоз хэлбэр
  2. Эритематоз – буллез
  3. Буллез – цусархаг
  4. Шархлаат
  5. Фибринт өнгөрт
- /122./ Архаг В гепатитын эмчилгээнд зайлшгүй шаардлагатай эмчилгээний аргыг сонгоно уу?
1. Эссенциале форте 2 калсул өдөрт 3 удаа 2 сар уух
  2. Интерферон схемээр тарих

3. Легалон 90 мг өдөрт 3 удаа уух
  4. Ламивудин 100 мг өдөрт 1 удаа уух
  5. Витамин .С. 5% - 2.0 + Глюкозын хамт тарих
- /123./ Аденовирус халдвар эмнэл зүйн ямар хэлбэрүүдээр явагдах вэ?
1. Конъюнктивит
  2. Фарингит
  3. Кератит
  4. Колит
  5. Менингит
- /124./ Халдвартын больницын тасаг ямар зохион байгуулалттай вэ?
1. Ердийн палат
  2. Боксын
  3. Боксын бус
  4. Хагас боксын
  5. Төлбөртэй
- /125./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго
1. Ангина тод илрэх
  2. Ангина илрэхгүй
  3. Тууралт нүүрнээс эхэлнэ
  4. Арьс салст гэмтсэн байх
  5. Хоолойн булчирхай үрэвсэх
- /126./ Бруцеллез өвчний эмгэг жамын үе шатууд
1. Тунгалагаар зөөгдөх
  2. Цусны урсгалаар зөөгдөх
  3. Олон голомтот халдвар үүсгэх
  4. Голомтоос нян дахин цусанд эргэх
  5. Дархлаа тогтож, эдгэрэх
- /127./ Урвах тахлын эгэл бус хэлбэрүүдийг тэмдэглэ.
1. Өндөр настай хүмүүст
  2. Хуурай хэлбэр
  3. Жирэмсэн эмэгтэйд
  4. Цахилгаан хэлбэр
  5. Бага насны хүүхдэд
- /128./ Халдвар хордлогын шокийн үед дараах биологийн идэвхит бодисуудаас аль нь ялгардаггүй вэ?
1. Катехоламин
  2. Серотонин
  3. Тромбопластин
  4. Аденилциклаза
  5. Гистамин
- /129./ Иерсиниозын халдварыг тараах эх уурхай юу вэ?
1. Хулганы төрлийн мэрэгчид
  2. Гэршсэн мэрэгчид
  3. Шувууд
  4. Гэрийн тэжээмэл амьтад
  5. Хүмүүс
- /130./ Боомын үүсгэгч ямар хор ялгаруулах вэ?
1. Бүрхүүлийн
  2. Үхүүлэх хор
  3. Хавагнуулах
  4. Энтеротоксин
  5. Некротоксин
- /131./ Улаан эсэргэний тууралтын үндсэн шинжийг сонго.
1. Том толбот гүвдрүүн тууралт
  2. Жижиг цэгэн улаан тууралт
  3. Цэврүүт тууралт

4. Загатнана
  5. Арьсны өнгө хэвийн
- /132./ Герпес вирус нь:
1. РНХ агуулсан
  2. ДНХ агуулсан
  3. Эсийн гадна өсөж үрждэг
  4. Липид уургийн бүрхүүлтэй,
  5. Зөвхөн амьсгалын замаар халдварладаг
- /133./ Урвах тахлын эгэл бус хэлбэрүүдийг тэмдэглэ.
1. Өндөр настай хүмүүст
  2. Хуурай хэлбэр
  3. Жирэмсэн эмэгтэйд
  4. Цахилгаан хэлбэр
  5. Бага насны хүүхдэд
- /134./ Герпес вирусийн халдварын үед дараахь эмийн бэлдмэлүүдийг хэрэглэнэ
1. Ацикловир
  2. Рибавирин
  3. Алпизарин
  4. Видарабин
  5. Вальцикловир
- /135./ Гахайн хавдрын үед төмсөг хавдсан үед ямар эмчилгээ хийх вэ?
1. Хүйтэн жин тавих
  2. КС гормон
  3. Сойж боох
  4. УВЧ
  5. Бүлээн жин
- /136./ РС вируст халдварын эхэн үед эмнэлзүйн ямар шинжүүд гарах вэ?
1. Ханиах
  2. Булчингаар өвдөх
  3. Өндөр халуурах
  4. Толгой өвдөх
  5. Цэр гарах
- /137./ Урвах тахал өвчний баасны шинж чанарыг тэмдэглэ.
1. Усархаг
  2. Хэмжээ их
  3. Үнэргүй
  4. Цусны судалтай
  5. Хоолны үлдэцтэй
- /138./ Бруцеллезтэй өвчтөнг хэдийд халуун шавар, рашаан, сувилалд явуулж болох вэ?
1. Цочмог хэлбэр
  2. Үлдэц хууч
  3. Архаг үрэвсэл сэдэрсэн
  4. Архаг үрэвсэл намдсан
  5. Аль ч үед болно
- /139./ Улаан эсэргэнэ өвчний үед арьсан дээр ямар өөрчлөлт илрэх вэ?
1. Цэгчилсэн толбо-гүвдрүү гарна.
  2. Гуужилт
  3. Арьсны зураглал цагаан
  4. Арьс чийглэг
  5. Мөчдийн үзүүр хүйтэн
- /140./ Цочмог цусан суулгын колитын хэлбэрийн үед ямар шинжүүд илрэх вэ?
1. Өвчний эхлэл хурц
  2. Хий дүлнэ
  3. Хэвлийн доод хэсгээр базалж өвдөнө
  4. Ус ихтэй суулгана
  5. Маш их хөстэй

/141./ Элэгний цочмог энцефалопатийг эмчлэхэд зайлшгүй чухал эмчилгээний аргуудыг сонго.

1. Тархины хаванг бууруулах
2. Ходоод гэдсийг цэвэршүүлэх
3. Уургийн задралыг саатуулагч ферментүүдийг тарих
4. Хүчилтөрөгч амьсгалуулах
5. Хордлого тайлах

/142./ Бичил биетнийг эмгэг төрүүлэгч чадвараар нь хэдэн бүлэгт хуваадаг вэ?

1. Эмгэг төрүүлэгч,
2. Эмгэг бус төрүүлэгч,
3. Болзолт эмгэг төрүүлэгч
4. Нян
5. Вирус

/143./ Бруцеллезийн халдвар дамжих замуудыг сонго

1. Ахуйн хавьтал
2. Агаар тоос
3. Хоол боловсруулах
4. Шавьж, мэрэгчид
5. Цусаар

/144./ Халдвар хордлогын шокийн үед арьсан дээр гарах тууралт:

1. Цөөн тооны гүвдрүүт
2. Олон тооны жижиг үхжилттэй цусархаг
3. Цөөн тооны цусархаг
4. Том том цөөн тооны үхжилттэй цусархаг
5. Олон тооны цэврүүт

/145./ Галзуу өвчний эхэн үед ямар шинжүүд илрэх вэ?

1. Айж сандрах
2. Нойронд муу
3. Шархны орчим өвдөх, хорсох ирвэгнэ
4. Халуурах
5. Гар хөл ирвэгнэж мэдээ алдах

/146./ В гепатитын үүсгэгчийн эсрэг төрөгчдийг тэмдэглэнэ үү?

1. HBsAg
2. HBcAg
3. HBe Ag
4. HA-Ag
5. HDcAg

/147./ Халдвар хордлогын шок үүсэж буй гол механизм нь:

1. Бодисын солилцооны гаралтай хүчилшил,
2. Судсан дотор цус түгэн бүлэгнэх хамшинж
3. Эд эсийн хүчилтөрөгчийн дутал
4. ТМТ-ы хордлого
5. Бичил эргэлтийн хямрал

/148./ Халдварт мононуклеозын үед илрэх гол шинж тэмдгүүд:

1. Халуурах
2. Лимфаденит
3. Ангина
4. Тууралт
5. Суулгалт

/149./ Томуугийн үүсгэгчийн шинжүүдийг түүж бич.

1. Ретровирус
2. Ортомиксовирус
3. ДНХ агуулсан
4. Хатаах буцалгахад амархан үхнэ
5. Гадаад орчинд тэсвэртэй

/150./ Балнад өвчний үед тохиолдох онцлог шинжүүдийг сонгоно уу?

1. Өнгөртэй зузаан хэл
  2. Падалкийн шинж
  3. Филлипповичийн шинж
  4. Стефанскийн шинж.
  5. Гиппократын царай
- /151./ Герпес вирус дараахь дэд бүлгүүдэд хуваагдана
1. Альфа
  2. Гамма
  3. Бетта
  4. Сигма
  5. Эпсилон
- /152./ Урвах тахал өвчний баасны шинж чанарыг тэмдэглэ
1. Усархаг
  2. Хэмжээ их
  3. Үнэргүй
  4. Цусны судалтай
  5. Хоолны үлдэцтэй
- /153./ В гепатитаас сэргийлэх тарилгыг тарих насыг зөв сонго.
1. Төрсний дараа 24 цагийн дотор
  2. 2 сартайд
  3. 3 сартайд
  4. 4 сартайд
  5. Бүгд зөв
- /154./ Томуу өвчний эхлэл үеийн шинжүүдийг нэрлэ.
1. 38.5-40 хэм хүрч халуурна
  2. Толгой өвдөнө
  3. Үе мөч, булчингаар шархирч өвдөнө
  4. Ханиалгана
  5. Хамар битүүрнэ
- /155./ Архаг гепатит, элэгний цирроз, хавдарын шалтгаан болдоггүй вирусүүдийг тэмдэглэ.
1. Гепатитын С вирус
  2. Гепатитын А вирус
  3. Эпштейн Баррын вирус
  4. Гепатитын Е вирус
  5. Гепатитын D вирус
- /156./ Урвах тахал өвчний баасны шинж чанарыг тэмдэглэ.
1. Усархаг
  2. Хэмжээ их
  3. Үнэргүй
  4. Цусны судалтай
  5. Хоолны үлдэцтэй
- /157./ Бруцеллез өвчний үед антибиотик эмчилгээ хийх заалтуудыг сонго.
1. Анхдагч далд хэлбэр
  2. Цочмог хэлбэр
  3. Үлдэц хууч
  4. Үхжил - үсэрхийлсэн
  5. Архаг үрэвсэл намдсан
- /158./ Улаан эсэргэнэ өвчтөний царай ямар байх вэ?
1. Цонхигор
  2. Хацар нь улайсан
  3. Хамар уруулын гурвалжин хөх
  4. Хамар уруулын гурвалжин цагаан
  5. Зовхи хавдсан
- /159./ Гахай хавдрын эгэл хэлбэрийн эмчилгээг тэмдэглэ
1. УВЧ-ээр шарах
  2. Бүлээн ба спиртэн бигнүүр

3. Шүлс бага ялгаруулах шингэвтэр хоол
  4. Хацарт хүйтэн жин
  5. Цус тогтоох эмчилгээ зайлшгүй хийнэ
- /160./ Герпес вирүсийн оношлогоонд лабораторийн дараахь аргуудыг хэрэглэнэ
1. Ийлдэс судлалын
  2. Вирүс судлалын
  3. Эс судлалын
  4. Нян судлалын
  5. Биохимийн
- /161./ Герпес вирүсийн халдвараас сэргийлэх өвөрмөц арга нь аль вэ?
1. Анатоксин
  2. Иммуноглобулин
  3. Антибиотик
  4. Вирүсийн эсрэг бэлдмэлүүд
  5. Нийлмэл вакцин
- /162./ Халдварт өвчний санаа авахуулах шинжид ямар шинжүүд хамаарах вэ?
1. Халуурах
  2. Дотор муухайрах
  3. Бие сулрах
  4. Туурах
  5. Баасны шинж өөрчлөгдөх
- /163./ Сахуугийн үед элбэг тохиолдох хүндрэлүүдийг заа.
1. Гломерулонефрит
  2. Миокардит
  3. Синовит
  4. Нефрит
  5. Кератит
- /164./ Халдвар хордлогын шокийн эмнэл зүйн зэргийн шалгуурт орох үзүүлэлтүүдийг тэмдэглэ.
1. Цусархаг тууралтын байдал
  2. Артерийн даралтын түвшин болон Гведалийн шинж
  3. Шээсний хэмжээ
  4. Суулгалтын тоо
  5. Гэдэс базлалтын тоо
- /165./ Хиамдал өвчин үүсэх нөхцөл бол.....
1. Нөөшилсөн мөөг идэх
  2. Нөөшилсөн өргөст хэмх идэх
  3. Утсан махан бүтээгдэхүүн идэх
  4. Жимсний чанамал идэх
  5. Жимсний шүүс уух
- /166./ Халдвартын бүтэн боксонд ямар өвчтөнг хэвтүүлэх вэ?
1. Онош тодорхойгүй өвчтөн
  2. Агаар дуслын халдварт өвчтэй хүн
  3. Гоц халдварт өвчтэй
  4. Гэдэсний халдварт
  5. Бэлгийн замын халдварт өвчтэй
- /167./ Менингококкийн халдварын үед дараахь хүндрэлүүд эрт үед тохиолддог
1. Халдвар хордлогын шок
  2. Тархины цочмог хаван
  3. Бөөрний цочмог дутал, бөөрний дээд булчирхайн цочмог дутал,
  4. Ларингит
  5. Цус алдалт
- /168./ Татрангийн өвөрмөц эмчилгээнд дараах бэлдмэлүүд орно:
1. Тайвшруулах, таталтын эсрэг бэлдмэлүүд
  2. Татрангийн хорын эсрэг ийлдэс
  3. Антибиотик

4. Татрангийн иммуноглобулин
  5. Сульфаниламид
- /169./ Балнад өвчний халууралтын онцлог шинжүүдийг сонгоно уу?
1. Өдөр ирэх тутам даамжирна
  2. Хөлрөхгүй
  3. Арьс хуурай
  4. Халуунтай тохирсон тахикарди илэрнэ
  5. Чичирнэ, хөлөрнө
- /170./ Архаг В гепатитын үед Интерферон эмчилгээ хийх үзүүлэлтүүдийг сонго.
1. Алат фермент хэвийн байх
  2. HBe Ag / + /
  3. Тимол өндөр байх
  4. АлАт ферментийн идэвх 2-5 дахин их байх
  5. Альбумины хэмжээ буурах
- /171./ Улаан бурхны хөнгөрүүлсэн /митигированная/ хэлбэрийн онцлог
1. Хөнгөн явцтай
  2. Нууц хагацаа урт
  3. Улайралтын шинж тэмдгүүд бүдэг
  4. Хүнд явцтай
  5. Тууралт дэс дараатай
- /172./ Элэгний эсийг дутлыг илтгэх биохимийн үзүүлэлтүүдийг сонго.
1. Альбумин буурах
  2. Протромбины индекс буурах
  3. Бета – липопротейд буурах
  4. Билирубин буурах
  5. Сульма буурах
- /173./ Балнад өвчний үед ямар халууралт байх вэ?
1. Вундерлихийн
  2. Килдюшевскийн
  3. Боткины
  4. Гектический
  5. Халуунгүй
- /174./ Архаг гепатит, элэгний цирроз улмаар хавдар үүсгэдэг вирусүүдийг тэмдэглэ
1. Гепатитын D вирус
  2. Гепатитын B вирус
  3. Гепатитын C вирус
  4. Гепатитын A вирус
  5. Гепатитын E вирус
- /175./ Бруцеллийн эмгэг төрүүлэгч чанарыг тэмдэглэнэ үү?
1. Гадар хор ялгаруулдаг
  2. Эд, эсэд нэвтрэх инвазив чанар сайн
  3. эсийн үхжил үүсдэг
  4. Эсийн дотор шимэгчлэн орших
  5. Тэжээлт орчинд хурдан ургана
- /176./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго.
1. Нууц хугацаа 2-7 хоног
  2. Ангина илрэхгүй
  3. Тууралт нүүрнээс эхэлнэ
  4. Арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдсан байна
  5. Эрүүн дорхи лимфаденит болно
- /177./ Менингококкийн халдварын үеийн хожуу тохиолдох хүндрэлд дарааь хүндрэлүүд орно.
1. Халдвар хордлогын шок
  2. Эпилепсийн уналт
  3. Тархины цочмог хаван
  4. Тархины дотоод даралт ихсэх хамшинж
  5. Бөөрний дээд булчирхайн цочмог дутал

/178./ Гахай хавдар өвчний ид үед эмнэл зүйн ямар шинжүүд илрэх вэ?

1. Ам ангайж болохгүй өвдөнө
2. Хоёр талын шүлсний булчирхай хавдсан
3. Бага зэрэг халуурна
4. Толгой таллаж хүчтэй өвдөнө.
5. Маш их хэмжээгээр бөөлжинө

/179./ IgG –ийн үндсэн шинжүүдийг тэмдэглэнэ үү?

1. Хожуу үед үүснэ
2. Нийт иммуноглобулины 70-80% эзэлнэ
3. Нэвчих , хавсарга холбох урвалд их идэвхтэй
4. Наалдуулах , задлах урвалд идэвхтэй
5. Эрт үед үүснэ.

/180./ Төвөнхийн сахуугийн эмнэл зүйн шинжүүд юу вэ?

1. 38 хэм хүртэл халуурна
2. Хоолой сөөж ханиана
3. Төвөнхийн салстад зузаан өнгөр тогтдог
4. Гүйлсэн булчирхай, хүүхэн хэл зузаан саарал өнгөртэй
5. Гүйлсэн булчирай эмзэглэлтэй

/181./ Influenza A вирүсийн бүрхүүлийн эсрэг төрөгчдийг тэмдэглэ.

1. Т-уураг
2. Нейраминадаза
3. М-уураг
4. Гемагглютинин
5. И-ацетилглюкозамин

/182./ Хөхүүл ханиалгын үеийн эмнэлзүйн өвөрмөц шинжүүдийг нэрлэ.

1. Угсруулсан ханиалга
2. Салсархаг зүйлээр бөөлжих
3. Аура буюу зөн совин болон реприз
4. Хоолой сөөх
5. Халуурах

/183./ Сальмонеллуудын эсрэг бие өвчний аль үед илрэх вэ?

1. Эхний 2 цаг дотор
2. 1 хоногийн дараа
3. 2-3 хоногийн дараа
4. Эхний 7 хоногийн сүүл, 2.3 дахь долоо хоногт
5. 2-12 цаг

/184./ Татрангийн таталтын онцлогийг тэмдэглэ

1. Өвдөлттэй
2. Их хүчтэй
3. Татах үедээ ухаан алдахгүй
4. Богино хугацааны
5. Сул

/185./ Тархины цочмог хавангийн зэргийг дараах шинжүүд илэрхийлнэ.

1. Ухаан санааны байдал
2. Хүүхэн харааны урвал
3. Менингитийн шинжийг илрэх эрчим
4. Рефлекс
5. Хөхрөлт

/186./ Балнад өвчний тууралт зонхилон хаана гардаг вэ?

1. Нүүрэн дээр
2. Алга,улан дээр
3. Гарын сарвуу, нуруун дээр
4. Цээж хэвлий орчим
5. Толгойн хэсгээр

/187./ Улаан бурхан өвчний халдвартай үеийг тэмдэглэ.

1. Нууц үеийн төгсгөл



2. Улайралтын үе
  3. Тууралтын үе
  4. Нөсөөжилтийн үе
  5. Өвчний бүх үе шатанд
- /188./ Цочмог вирүст хепатит өвчний шарлалтын өмнөх үед илрэхгүй хам шинжүүдийг сонго.
1. Элэг, дэлүү томрох
  2. Арьс, салст шарлах
  3. Мэнэн төст
  4. Томуу төст
  5. Ходоод гэдэс хямрах
- /189./ Хүний биеийн өвөрмөц хамгаалах тогтолцоонд юу хамаарах вэ?
1. В - лимфоцит ба дархлааны ой дурсамж
  2. түргэн зуурын хэт мэдрэг чанар
  3. эсрэг бие үүсэх
  4. Макрофаг
  5. Шүлс,
- /190./ Балнад өвчний өвөрмөц бус хүндрэлийг тэмдэглэнэ үү?
1. Гломерулонефрит
  2. Дисбактериоз
  3. Усгүйжилт
  4. Нарийн гэдэснээс цус алдах
  5. Гэдэс цоорох
- /191./ Сахуугийн савханцар ямар хор фермент ялгаруулдаг вэ?
1. Гиалуранидаза
  2. Нейраминадаза
  3. Гадар хор
  4. Дотор хор
  5. Цистиназа
- /192./ Аденовируст халдварын үед ямар шинжилгээг хийх вэ?
1. Бактерлоги
  2. Вирусологи
  3. Харшлын
  4. Серологи
  5. Биологийн
- /193./ Тархины цочмог хавангийн зэргийг дараахь шинжүүд илэрхийлнэ
1. Ухаан санааны байдал
  2. Хүүхэн харааны урвал
  3. Мэнэнгийн шинжийн илрэх эрчим болон рефлекс
  4. Тууралтын байдал
  5. Халууралт
- /194./ Гахай хавдрын үед шүлсний булчирхайн хавдрын онцлог ямар байх вэ?
1. Хавдар хатуу
  2. Хавдарын өнгө нь өөрчлөгдөөгүй
  3. Хавдсан хэсэг халуун, эмзэглэлтэй
  4. Хавдарын орчимд ямар ч өөрчлөлтгүй
  5. Хавдсан хэсгийн арьс улайсан
- /195./ Цусан суулгыг оношлоход оношлогооны ямар аргуудыг голлон ашигладаг вэ?
1. Нян судлал
  2. Копрологи
  3. Серологи
  4. Фермент холбоот эсрэг биеийн урвал
  5. Вирүс судлал
- /196./ Varicella Zoster вирүсийн халдварын гаж хэлбэрүүдийг тэмдэглэ.
1. Том цэврүүт хэлбэр
  2. Үхжилт хэлбэр
  3. Цусархаг хэлбэр

4. Хөнгөн хэлбэр
  5. Хүнд хэлбэр
- /197./ Хөхүүл ханиадын үүсгэгч нь дараахь эсрэг төрөгчидтэй.
1. Агглютиноген
  2. Гемагглютинин
  3. Протектив
  4. Дотор хор
  5. Гадар хор
- /198./ Татрангийн эхлэл үеийн шинжүүдийг тэмдэглэ
1. Хараа муудах, зовхи буух
  2. Тризм, сардоник инээмсэглэл
  3. Амьсгаадалт, амьсгал бачуурах
  4. Юм залгиж чадахгүй
  5. Бөөлжих, халуурах, толгой өвдөх
- /199./ Менингококцемийн үед илрэх өвөрмөц шинжийг тэмдэглэнэ үү?
1. Толгой хүчтэй өвдөх
  2. Цусархаг тууралт гарах
  3. Олон удаа бөөлжих
  4. Гэнэт өндөр халуурах
  5. Ухаан алдах
- /200./ Боомын арьсны хэлбэр ямар байдлаар илрэх вэ?
1. Ёлом төст
  2. Идээт
  3. Цэврүүт
  4. Буглаат
  5. Шархлаат
- /201./ IgM –ийн үндсэн шинжүүдийг тэмдэглэнэ үү?
1. Хожуу үед үүснэ
  2. Эрт үед үүснэ
  3. Нийт иммуноглобулины 70-80% эзэлнэ
  4. Наалдуулах , задлах урвалд идэвхтэй
  5. Нэвчих , хавсарга холбох урвалд их идэвхтэй
- /202./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго.
1. Нууц хугацаа 2-7 хоног
  2. Ангина илрэхгүй
  3. Тууралт нүүрнээс эхэлнэ
  4. Арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдсан байна
  5. Эрүүн доорхи тунгалагийн булчирхай томорно
- /203./ Сальмонеллезын ходоод гэдэсний хэлбэрт орохгүй хувилбарыг сонго.
1. Гастрит
  2. Балнад төст
  3. Гастроэнтерит
  4. Идээт үжил
  5. Гастро-энтероколит
- /204./ Менингококцемийн үед илрэх өвөрмөц шинжийг нэрлэ
1. Толгой хүчтэй өвдөх
  2. Цусархаг тууралт гарах
  3. Олон удаа бөөлжих
  4. Гэнэт өндөр халуурах
  5. Ухаан алдах
- /205./ Гепатитын А вирусийн халдварын дамжих хүчин зүйлийг тэмдэглэнэ үү?
1. Ус
  2. Хоол хүнс
  3. Бохир гар
  4. Зүү тариур
  5. Цус

/206./ Хиамдал өвчний үүсгэгчийн хорыг..... илрүүлнэ

1. Ходоод угаасан усанд
2. Хоолны үлдцэнд
3. Бөөлжисөнд
4. Өтгөнд
5. Цусанд

/207./ Хүний биеийн өвөрмөц бус хамгаалах тогтолцоонд юу хамаарах вэ?

1. Арьс салстын хамгаалах урвал,
2. Лизоцим ба ходоодны хүчил
3. Амьсгалын замын намираа хучуур эд
4. Т- лимфоцит
5. Эсрэг бие

/208./ Хөөмийн сахуугийн хордлогот хэлбэрийн үед ямар хүндрэлүүд илэрч болох вэ?

1. Хордлогот миокардит
2. Тагнай , залгиурын саа
3. Нефроз
4. Менингит
5. Уушгины хатгаа.

/209./ Ясны радиоизотопийн ямар өөрчлөлтийг илрүүрж үнэлж болох вэ?

1. Ясанд метастаз өгсөн эсэхийг
2. Ясанд анхдагч өмөн байгааг
3. Хавдрын эдийн бүтцийг
4. Яс тэнхлэгийн дагуу гэмтсэн
5. Эмгэг хугарал гэмтлийг илрүүлэх

/210./ Умайн хүзүүний өмөнг эрт илүүлж оношлоход ямар арга нь илүү вэ?

1. Эмэгтэйчүүдийн эмчид үзүүлэх
2. Кольпоцитодиагностик
3. PAP сорил
4. Үтрээний эхо
5. Хусаж шинжлэх

/211./ Улаан хоолойн үйл ажиллагааг ямар аргаар үнэлж болох вэ?

1. “Өтгөн баритай” рентгенд харах
2. Шингэн баритай рентген хийх
3. Амьсгалын эрхтэн ба улаан хоолойн полирентгенографи хийх
4. Эксфолиатив цитодиагностик
5. Дурандаж биопси авах

/212./ Зөөлөн эдийн хавдар голчлон хаана байрладаг вэ?

1. Булчингийн давхаргад
2. Дээд доод мөчдөд
3. Цавинд
4. Цээжний хэсэгт
5. Хэвлийн хөндийн эрхтэнүүдэд

/213./ Хөхний хавдрыг ямар өвчнөөс ялган оношлох шаардлагатай вэ?

1. Зангилаат мастит
2. Гемобластоз
3. Мастит
4. Туберкулёз
5. Дээрх бүх хариулт зөв

/214./ Морфин хэрэглэж буй өвчтөнд илэрч болох гаж үйлчилгээ

1. амьсгал дарангуйлагдах
2. өтгөн хатах
3. дотор муухайрах бөөлжих
4. нойрмог болж унтаарах
5. хөлрөмтгий болох

/215./ Өндгөвчний үйл ажиллагааг ямар аргаар дарангуйлах вэ?

1. Лапароскопийн тусламжтай өндгөвч авах

2. Туяа эмчилгээний тусламжтай
3. Гозерелин
4. Тамоксифен
5. Дээрх бүгд зөв

/216./ Ясны өмөнгөөр нэдэн насны хүн илүү өвчилдөг вэ?

1. 1-5 нас
2. 10-20 нас
3. 21-30 нас
4. 40-50 нас
5. 60-аас дээш нас

/217./ Ямар эмгэгийн үед цөмөлж авах оношлогооны үр дүн илүү байдаг вэ?

1. Арьсны меланома
2. Ясны эдийн саркома
3. Арьсны хавдар
4. Лимфома
5. Аденокарцинома

/218./ Улаан хоолойн өмөнгийн эпидермиологийн хувьд аль хариулт нь зөв бэ?

1. Эмэгтэйчүүд илүү өвчлөмтгий байдаг
2. 50-ээс дээш насныханд илүү тохиолддог
3. Баруун аймгийн иргэдэд илүү тохиолддог
4. Хойд зүгийн уугуул иргэдэд илүү тохиолддог
5. Өмнөговь аймгийн хүмүүст

/219./ Хөхний өмөн ямар эрхтэнд голчлон үсэрхийлдэг вэ?

1. Уушиг
2. Яс
3. Элэг
4. Тархи
5. Дээрх бүх эрхтэнд

/220./ Ходоодны хавдар нугалуур хэсэгт байрласан үед ямар үйл ажиллагаа алдагдах вэ?

1. Моторно-эвакуатор
2. Ревезуар
3. Шүүрлийн
4. Бактерицид
5. Кроветвор

/221./ Морфин хэрэглэж буй өвчтөнд илэрч болох гаж үйлчилгээ

1. амьсгал дарангуйлагдах
2. өтгөн хатах
3. дотор муухайрах бөөлжих
4. нойрмог болж унтаарах
5. хөлрөмтгий болох

/222./ 36 настай, баруун хөхний гадна дээд хэсэгт байрласан T1N0M0 үе шат бүхий хавдрыг радикал тайралт хийж авсан. Цаашид ямар эмчилгээ төлөвлөх вэ?

1. Ажиглах
2. Туяа эмчилгээ
3. Эстроген дааврын эсрэг эмчилгээ
4. Урьдчилан сэргийлэх хими эмчилгээ
5. Өндгөвч авах мэс засал

/223./ Ямар хүчин зүйлүүд эмгэг өөрчлөлтийг үүсгэдэг вэ?

1. 60-аас дээш настайд авсан гэмтэл
2. 50-аас дээш настай тамхи татдаг
3. Ясан дээрх хавдрын деструкци өөрчлөлт
4. Туяаны нөлөө
5. Хими эмчилгээ

/224./ Улаан хоолойн төгсгөл буюу кардийн булчирхайлаг өмөнг ямар гол аргаар эмчлэх юэ?

1. Туяа эмчилгээ
2. Полихими эмчилгээ

3. Хооллох еюностоми
  4. Улаан хоолойн доод 1/3 ба ходоодны хэсгийн субтоталт тайралт
  5. Пластик гуурс тавих
- /225./ Уушигны өмөн ямар эдээс үүсдэг вэ?
1. Эпители
  2. Мэдрэл
  3. Мөгөөрс
  4. Яс
  5. Булчирхай
- /226./ Хөхний өмөнг оношлох ямар арга илүү найдвартай вэ?
1. Маммографи
  2. Цитологи шинжилгээ
  3. Дуктографи
  4. ЭХО
  5. Эдийн шинжилгээ
- /227./ Хавдар ходоодны амсар хэсэгт байрласан үед ямар шинж илрэх вэ?
1. Дисфаги
  2. Өлөн үед “ус дусах” чимээ гарах
  3. Гулгих
  4. Шүлс ихээр ялгарах
  5. Цээжний ард хөндүүрлэж өвдөх
- /228./ Туяа эмчилгээний улмаас үүссэн улаан хоолойн үрэвслийн үед илрэх шинжүүд:
1. зогьсуулах
  2. өвчүүний ард хөндүүрлэж өвдөх
  3. цустай бөөлжих
  4. халуурах
  5. хэврүүлэх
- /229./ Аль арга нарийвчлалыг илүү тодорхойлох вэ?
1. “Өтгөн баритай” рентгенд харах
  2. Амьсгалын эрхтэн ба улаан хоолойн полирентгенографи хийх
  3. Тодосгогч бодистой КТГ
  4. Эксфолиатив цитодиагностик
  5. Дурандаж браш биопси авах
- /230./ Ходоодны ёроол хэсэгт хавдар байрласан үед хамгийн түрүүнд ямар үйл ажиллагааг алдагдах вэ?
1. Моторно-эвакуатор
  2. Ревезуар
  3. Шүүрлийн
  4. Бактерицид
  5. Кроветвор
- /231./ Улаан хоолойн салст бүрхэвчийн өөрчлөлтийг ямар аргаар оношлож болох вэ?
1. “Өтгөн баритай” рентгенд харах
  2. Шингэн баритай рентген хийх
  3. Амьсгалын эрхтэн ба улаан хоолойн полирентгенографи хийх
  4. Эксфолиатив цитодиагностик
  5. Дурандаж биопси авах
- /232./ Хөхний өмөнгийн ямар хэлбэр тавилан муутай вэ?
1. Нэвчдэст хавантай хэлбэр
  2. Зангилаат хэлбэр
  3. Олон хэлбэр
  4. Байран өмөн /in situ/
  5. Педжетийн хавдар
- /233./ Хөхний өмөн ямар замаар үсэрхийлдэг вэ?
1. Гематоген
  2. Лимфоген
  3. Имплантаци

4. Гематоген болон лимфоген
5. Дээрх бүх замаар

/234./ Хөхний өмөнгийн ямар үе шатанд Пейтийн аргаар хөх авах төгс мэс засал хийх боломжгүй вэ?

1. Цээжний жижиг булчин
2. Эгэмний доорх өөхөн эд
3. Суганы доорх өөхөн эд
4. Далны доорх өөхөн эд
5. Цээжний том булчинд

/235./ Хөхний өмөнгийн аль хэлбэрийн үед дааврын эмчилгээг хийх шаардлагатай вэ?

1. Анхдагч хөхний өмөнгийн бүх үе шатанд
2. Анхдагч тархмал хавдар
3. Хавдрын дааврын рецептор тодорхой үед
4. Жирэмслэлт болон хөхний сүүжилттэй холбоотой хавдар
5. Менопаузтай холбоотой хавдар

/236./ Дор дурдсан шинж тэмдгийг багасгах зорилгоор хөнгөвчлөх туяа эмчилгээг хийдэг.

1. өвдөлт
2. ясны эмгэг хугаралт
3. Цус алдалт
4. Хөлрөх
5. Цус багадах

/237./ Уушигны хавдрыг илрүүлэхэд анхдагч шинжилгээнүүдийг нэрлэнэ үү?

1. Плеврийн шингэнд хавдрын эс үзэх
2. Цээжний рентген зураг
3. Цээжний гаднаас хатгалт хийх
4. Цээжний КТГ
5. Бүгд

/238./ 35 настай 8н долоо хоногтой жирэмсэн эмэгтэйн баруун хөх хатууран томорч, хөхний толгойноос цусархаг ялгадас гарч улмаар баруун суганы тунгалагийн булчирхай томорсон. Ямар арга хэмжээ авах вэ?

1. Физик эмчилгээ
2. Баруун хөх болон суганы тунгалагийн булчирхайнаас эсийн шинжилгээ авах
3. Антибиотик эмчилгээ хийх
4. Маммографи
5. Дээрх бүгд зөв

/239./ Дор дурдсан шинж тэмдгийг багасгах зорилгоор хөнгөвчлөх туяа эмчилгээг хийдэг.

1. өвдөлт
2. ясны эмгэг хугаралт
3. Цус алдалт
4. Хөлрөх
5. Цус багадах

/240./ Хөхний хавдрыг эрт илрүүлж оношлоход ямар арга нь илүү вэ?

1. Маммографи
2. Хөхөө өөрөө шалгах
3. Хөхний эхо
4. КТГ
5. Мэс заслын эмчид үзүүлэх

/241./ Өндгөвчийн поликистозын үед:

1. Фолликул сэдээгч дааврын түвшин ихэснэ
2. Лактогены дааврын түвшин ихэснэ
3. Фолликул сэдээгч, Лактогены дааврын түвшин ихэснэ
4. Фолликул сэдээгч дааврын түвшин буурна
5. Фолликул сэдээгч, Лактогены дааврын түвшин ихсэхгүй

/242./ Ясны хорт хавдар голчлон ямар эрхтэн рүү үсэрхийлдэг вэ?

1. Элэг
2. Уушиг

3. Зөөлөн эд рүү

4. Дэлүү

5. Тунгалагын зангилаа руу

/243./ Биопси нь оношлогооны өндөр ач холбогдолтой арга. Ямар хавдрыг оношлоход биопси илүү ач холбогдолтой вэ?

1. Яс

2. Хөх

3. Арьсны меланома

4. Зөөлөн эдийн хавдар

5. Ясны анхдагч ретуколсаркома

/244./ Ясны хавдрыг оношлох гол арга нь:

1. КТГ

2. Биопси

3. Эхо

4. Маркер

5. Рентген зураг

/245./ Морфологи бүтцээр нь зөөлөн эдийн хавдрыг юу гэж ангилдаг вэ?

1. Синовияль

2. Карциноид

3. Мезотелиол

4. Полип

5. Нейроген

/246./ Ямар шалтгаанаас болж хавдар үүсэх вэ? /яс/

1. Өсөлтийн бүс дэх бодисын солилцооны алдагдал /эпифизийн мөгөөрсөн хэсэгт/

2. Хуучин гэмтлээс

3. Ясны бэртэл өөрчлөлт

4. Паратириод гаралтай остеодистрофи

5. Төрөлхийн ясны гэмтлээс

/247./ Улаан хоолойн өмөнг ямар аргаар эрт илрүүлж оношлож болох вэ?

1. “Өтгөн баритай” рентгенд харах

2. Амьсгалын эрхтэн ба улаан хоолойн полирентгенографи хийх

3. Бронхоскопи

4. Эксфолиатив цитодиагностик

5. Хромотографийн аргаар дурандаж биопси авах

/248./ Ямар хавдар тамхитай холбоотой үүсдэг вэ?

1. Нойр булчирхайн хавдар

2. Уушиг

3. Амны хөндийн салст бүрхэвчийн хавдар

4. Давсагны хавдар

5. Улаан хоолой

/249./ Ходоодны хавдраас урьдчилан сэргийлэх анхдагч ямар арга байх вэ?

1. Утсан болон давсалсан бүтээгдэхүүн бага хэрэглэх

2. Хоол ундаа яаралгүй идэх

3. Ногоон өнгийн жимс, ногоог түлхүү хэрэглэх

4. Хатуу спиртийн төрлийн ундаанаас татгалзах эсвэл минерал болон содтой устай цуг хэрэглэх

5. Дээрх бүгд зөв

/250./ Юунаас болж трахеозофагийн свищ үүсдэг вэ?

1. Улаан хоолойн дунд хэсгийн өмөн

2. Улаан хоолойн доод хэсгийн өмөн

3. Улаан хоолойн өмөн цагаан мөгөөрсөн хоолой руу цөмөрсөнөөс

4. Улаан хоолойн дээд хэсгийн өмөн

5. Улаан хоолойн доод дунд хэсгийн өмөн

/251./ Ходоодны хавдар аль хэсэгт байрласан үед огих болон бөөлжилт үүсдэг вэ?

1. Амсар хэсэгт

2. Ёроол болон их биед
3. Бага махиа
4. Гарах хэсэгт
5. Их махиа

/252./ Хөхний хавдрын ямар тохиолдолд төгс мэс засал хийх вэ?

1. I үе
2. IIa үе
3. II б үе
4. III үе
5. IV үе

/253./ Хөхний өмөн ямар эдээс үүсдэг вэ?

1. Тунгалагийн зангилаа
2. Цусны судас
3. Гөлгөр эсвэл хөндлөн судалт булчингаас
4. Сүүний сувгийн эпителиээс
5. Дутуу хөгжсөн холбогч эдээс

/254./ Нэвчдэст хавант хавдрын үед ямар эмчилгээ хийх шаардлагатай вэ?

1. Мэс засал
2. Зөвхөн туяа эмчилгээ
3. Хими эмчилгээ
4. Хавсарсан эмчилгээ
5. Бүрдэл эмчилгээ

/255./ Эрт үеийн элэгний анхдагч өмөнгийн эмчилгээний сонголт юу вэ?

1. Мэс заслын тайралт
2. Элэг шилжүүлэн суулгах
3. Спирт шахах
4. Өндөр давтамжаар шарах
5. Элэгний артери бөглөх

/256./ Хавдрын эсрэг эмийн эмчилгээг юу гэдэг вэ?

1. Хими эмчилгээ
2. Дааврын эмчилгээ
3. Бай эмчилгээ
4. Туяа эмчилгээ
5. Хавсарсан эмчилгээ

/257./ Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөнд нөхцөл байдалтай холбоотой амьсгаадах шалтгаан

1. ядарч сульдах
2. цус багадах
3. өвдөлт
4. сэтгэл түгших
5. элэг томрох, хэвлийд шингэн хуримтлагдах

/258./ Туяа эмчилгээний хавдарт үйлчлэх механизм нь:

1. эсийн хромосомын аппаратыг гэмтээснээр дараагийн үеийн эсүүд үүсэлгүйгээр Үхэх
2. эсийн митоз хуваагдлын идэвхийг дарангуйлсанаар эсийн өсөлтийг саатуулах
3. орчны эрүүл эдийн урвал
4. захын цусны эсүүдийг дарангуйлах
5. эдэд сорвижилт үүсгэх

/259./ Ясны хавдар ихэвчлэн хаана байрладаг вэ?

1. Хавирга
2. Дунд чөмөг
3. Бугалга
4. Шилбэ
5. Сүүж

/260./ Өвчтөний эмчилгээний үр дүн юунаас хамаарах вэ?

1. Ясны изотоп шинжилгээний хариу
2. Хавдрын морфологи бүтэц



3. Биохимийн үзүүлэлт /ШФ, ЛДГ/
4. Хавдрын байрлал ба хэмжээ
5. Бөөр, нойр булчирхайн эхо

/261./ Зөөлөн эдийн хавдрын талаар ямар шинжилгээ нь илүү мэдээлэл өгдөг вэ?

1. Радиоизотопын арга
2. Соронзон резонанис томографи
3. КТГ
4. Биопси
5. Маркер

/262./ Ясны хоргүй хавдрын үед илэрдэг эмнэл зүйн гол шинжүүд

1. Электорлит солилцооны алдагдал /Ca, Na, K/
2. Хавдар байрласан хэсэгт шөнө өвдөх
3. Хавдар тэмтрэгдэх
4. Доголох
5. СОЭ ихсэх

/263./ Төвийн байрлалтай уушигны хавдрын морфологи бүтцийг шинжлэх гол арга нь юу вэ?

1. Цэрний шинжилгээ
2. Фибробронхископи
3. Трансторакаль
4. Унтуулгатай бронскопи
5. Медиастиноскопи

/264./ Хавдар ходоодны антраль буюу гарах хэсэгт байрласан үед ямар шинж илрэх вэ?

1. Өмхийгөөр хэхрэх
2. Хоол идсэний дараа бөөлжих
3. Аюулхайд хүнд оргих
4. Бөөлжсөний дараа хөнгөрөх
5. Дээрх бүгд зөв

/265./ 65 настай эмэгтэй, алганы болон чихний омогний арьс гуужиж эхэлсэнээс хойш нэг сарын дараагаас хоол горойж тээжлэж эхэлсэн. Ямар онош тавих вэ?

1. Акроцианоз
2. Улаан хоолойн хавдар
3. Ахалази
4. Дивертикул
5. Шарх сорвижсон

/266./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөг рүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьегийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар өвчин байх магадлал илүү өндөр байна вэ?

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/267./ 76 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Тэр шатаар явах үед амьсгааддаг байсан бол одоо тайван байх үедээ ч амьсгааддаг болсон. Орой болоход түүний хоёр шилбэ, шагайгаар хавансан байдаг. Шөнө босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв. Тэр ямар эмгэгтэй байх магадлалтай вэ?

- A. Чихрийн шижин
- B. Түрүү булчирхай томрох хам шинж
- C. Чихрийн бус шижин
- D. Зүрхний дутагдал, хаван шөнө бууснаас шээс шөнө элбэгшсэн байж болзошгүй

## Е. Цистит

/268./ 78 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 10% сийрэг болсон байгааг илрүүлсэн. Түүнд өрхийн эмч Кальц, Даминдэм бичиж өгсөн ба кальцаар баялаг тул сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэхийг зөвлөсөн. Тэр эмэгтэй залуугаасаа эхлээд чихэртэй байхуу, кофе уудаг байсан ба сүү, цагаан идээ хэрэглэж заншаагүй байв. Сүү, тараг хэрэглэж эхэлсэн өдрөөсөө тэр суулгаж, суулгалтанд Котримоксазол, Фталазол, Бифидум бактерин, Линекс зэргийг уусан боловч суулгалт намдахгүй 10 хоног. Тэр ямар шалтгаантай суулгасан бэ?

- A. Кальцийн бэлдмэл уусан тул
- B. Сүү нь муудсан тул суулгасан
- C. Лактазагийн дутагдалтай тул суулгасан
- D. Дисбактериоз болсон тул
- E. Д аминдэм суулгуулдаг тул

/269./ 88 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 25% сийрэг болсон байгааг илрүүлсэн ба түүний бүх биеийн яс янгинаж өвддөг зовиуртай тул гол төлөв хэвтэрт байдаг. Өвдөлт нь 2-3-р зэрэг. Түүнд бифосфонатын эмийн бүлгээс Кальцтай, Даминдэмтэй хамт хэрэглэхийг ямар тохиолдолд өрхийн эмч зөлөж болохгүй вэ?

- A. Ясны өвдөлттэй
- B. Бөөрний дутагдалтай
- C. Ясний сийрэгжилт 20%-иас бага
- D. Ясны эмгэг хугаралттай
- E. Зүрхний дутагдалтай

/270./ 70 настай өвгөн өөртөө үйлчлэх чадвартай тул өөрөө өглөөний цай ундаа уудаг ба өдөр өөртөө лапшаа, будаатай шөл мэтийн хөнгөн хоол хийж иддэг. Хоолны завсраар хааяа талх, боов иддэг. Өвгөнийг хүүхдүүд нь гэртэй орхиод өглөө бүр ажилдаа явдаг.

Оройн хоолыг хүүхдүүд нь хийдэг ба гэр бүлээрээ иддэг байв. Нэг өглөө өвгөн босоод өглөөний ундаа уух гэтэл ямар ч талх, боов, боорцог байсангүй. Будаа агшаах гэтэл будаа дууссан байв. Хөргөгчинд мах дууссан болохыг өвгөн анзаарч, 10 цагаас дэлгүүр онгойход дэлгүүр явж мах, будаа, талх авахаар шийдэв. Гэтэл түүнд маш бага мөнгө байсан тул тэр мах хямдхан бөөнддөг нилээд зайтай дэлгүүр явахаар шийдэв. Тэр 10 цаг болоход гэрээс гарч дэлгүүр зорьсон боловч, дэлгүүр 11 цагаас онгойв. Хүлээсээр байгаад дэлгүүрт орход махаа цавчихыг хүлээх болов. Тэр өглөөнөөс хойш юу ч идээгүй байсан тул ухаан нь орон гаран боллоо. Тэр гэртээ харих гэсэн боловч төөрчээ. Цагийн дараа өвгөн гудамжинд авцалдаагүй, дэмий юм ярж, зорчигчдыг харааж, үе үе чарлаж байв. Тэр яагаад дэмийрсэн бэ?

- A. Тэр тэнэгрэл зөнөгрөлтэй байсан тул.
- B. Шизофренидэй байсан тул
- C. Өлссөн ба цусны сахар багассан тул
- D. Хордлого болсон тул.
- E. Баас хатсан тул.

/271./ 70 настай өвгөн өөртөө үйлчлэх чадвартай тул өөрөө өглөөний цай ундаа уудаг ба өдөр өөртөө лапшаа, будаатай шөл мэтийн хөнгөн хоол хийж иддэг. Хоолны завсраар хааяа талх, боов иддэг. Өвгөнийг хүүхдүүд нь гэртэй орхиод өглөө бүр ажилдаа явдаг.

Оройн хоолыг хүүхдүүд нь хийдэг ба гэр бүлээрээ иддэг байв. Нэг өглөө өвгөн босоод өглөөний ундаа уух гэтэл ямар ч талх, боов, боорцог байсангүй. Будаа агшаах гэтэл будаа дууссан байв. Хөргөгчинд мах дууссан болохыг өвгөн анзаарч, 10 цагаас дэлгүүр онгойход дэлгүүр явж мах, будаа, талх авахаар шийдэв. Гэтэл түүнд маш бага мөнгө байсан тул тэр мах хямдхан бөөнддөг нилээд зайтай дэлгүүр явахаар шийдэв. Тэр 10 цаг болоход гэрээс гарч дэлгүүр зорьсон боловч, дэлгүүр 11 цагаас онгойв. Хүлээсээр байгаад дэлгүүрт орход махаа цавчихыг хүлээх болов. Тэр өглөөнөөс хойш юу ч идээгүй байсан тул ухаан нь орон гаран боллоо. Тэр гэртээ харих гэсэн боловч төөрчээ. Цагийн дараа өвгөн гудамжинд дэмий юм ярж, зорчигчдыг харааж, үе үе чарлаж байв. Түүнд юу тохиолдсон бэ?

- A. Тэр төөрсөн тул ууралсан.
- B. Тэр дэмийрч солиорсон.
- C. Тэр тэнэгрэл зөнөгрөлтэй байсан тул өвчин нь хөдөлсөн.
- D. Тэр өлсөж ууралсан.

Е. Түүний шизофрени хөдөлсөн.

/272./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөгрүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьегийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар эмчилгээ илүү үр дүнтэй вэ?

- A. Антибиотик
- B. Даавар эмчилгээ
- C. Сүрьеэгийн эсрэг эмчилгээ
- D. Аллопуринол эмчилгээ
- E. Гепарин эмчилгээ

/273./ 76 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Тэр шатаар явах үед амьсгааддаг байсан бол одоо тайван байх үедээ ч амьсгааддаг болсон. Тэр өглөө сэрэхэд хавангүй хэрнээ, орой болоход хоёр шилбэ, шагайгаар хавансан байдаг. Шөнө босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв. Түүний хаван ямар шалтгаантай үүссэн байх магадлал өндөртэй вэ?

- A. Бөөрний өвчний шалтгаантай хаван
- B. Зүрхний дутагдлын шалтгаантай хаван
- C. Тунгалгын хаван
- D. Элэгний дутагдлын ба үүдэн венийн даралт ихссэнтэй холбоотой хаван
- E. Уураг дутагдлын хаван

/274./ 74 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүний шээсний урсгал сул, бага багаар дүлж шээж байгаа, шээсэн хэрнээ давсанд шээс үлдэх мэт шинж илэрдэг ба заримдаа тэвчихэд хэцүү болдог гэж өгүүлсэн байв. Тэр ямар эмгэгтэй байх магадлалтай вэ?

- A. Чихрийн шижин
- B. Түрүү булчирхай томрох хам шинж
- C. Чихрийн бус шижин
- D. Зүрхний хаван шөнө бууснаас шээс элбэгшсэн байж болзошгүй
- E. Цистит

/275./ 69 настай эрэгтэйн тохой, өвдөгний арьсан дээр, чихний дотор талын арьсан дээр том гүвдрүүт боргоцой шиг ургацтай. Гүвдрүүг хаглахад аарц шиг цагаан зүйл гарна. Өвдөгний үеэр явахад өвддөг тул өвдөлт намдаахаар Ибупрофен уусан ба эмчид хандсан. Түүний шээсний шинжилгээнд оксалат, урат зэрэг давс ихээр илэрсэн. Түүнд ямар өвчин байх магадлал өндөр байна.

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/276./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 30 оноо бол юу гэж үнэлэх вэ?

- A. Эрүүл, зовиургүй, өвчний шинжгүй
- B. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.
- C. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай
- D. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг.
- E. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа

/277./ Тэнэгрэл зөнөгрөлийг оношлоход ямар асуумжийг ашигладаг вэ?

- A. Карновскийн асуумж
- B. Фолстейны мини асуумж
- C. Роберт Бакмены арга
- D. Спилбергийн асуумж

Е. САМ –ийн асуумж

/278./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 80 оноо бол юу гэж үнэлэх вэ?

- А. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.
- В. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай боловч өвчний зарим шинжүүд илэрсэн.
- С. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай
- D. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг
- Е. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа

/279./ 76 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Тэр шатаар явах үед амьсгааддаг байсан бол одоо тайван байх үедээ ч амьсгааддаг болсон. Тэр өглөө сэрэхэд хавангүй хэрнээ, орой болоход хоёр шилбэ, шагайгаар хавансан байдаг. Шөнө босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв. Түүний хаван ямар шалтгаантай үүссэн байх магадлал өндөртэй вэ?

- А. Бөөрний өвчний шалтгаантай хаван
- В. Зүрхний дутагдлын шалтгаантай хаван
- С. Тунгалгын хаван
- D. Элэгний дутагдлын ба үүдэн венийн даралт ихссэнтэй холбоотой хаван
- Е. Уураг дутагдлын хаван

/280./ 64 настай эрэгтэй, элэгний хатууралтай, хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд 3 литр орчим сул шингэн тогтоогдсон. Түүнд одоогоор амьсгаадах, өвдөх шинж илрээгүй байна. Түүнд 100 мг-аар Спиринолактоныг өглөө бүр уулгаж эхэлсэн. 2 сарын турш асцит багасаад бараг бараг байхгүй болсон байсан боловч 3 дах сараас хэвлийд дахин шингэн хуралдаж эхэлсэн. Одоо ямар арга хэмжээ авах вэ?

- А. Эмчилгээг үргэлжлүүлэх.
- В. Спиринолактоныг 200- 300 мг-аар өглөө бүр уулгах
- С. Фуросемид 40 мг-аар уулгах
- D. Фуросемид 80 мг-аар уулгах
- Е. Парацентез хийх

/281./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөг рүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьеэгийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар эмчилгээ илүү үр дүнтэй вэ?

- А. Антибиотик
- В. Даавар эмчилгээ
- С. Сүрьеэгийн эсрэг эмчилгээ
- D. Аллопуринол эмчилгээ
- Е. Гепарин эмчилгээ

/282./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 90 оноо бол юу гэж үнэлэх вэ?

- А. Эрүүл, зовиургүй, өвчний шинжгүй
- В. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн
- С. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай
- D. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа
- Е. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг

/283./ 83 настай эмэгтэй насны доройтлын улмаас хэвтэрт орсон. Түүнийг хэвтрийн цооролтоос урьдчилан сэргийлэхийн тулд С аминдэмийг хоногт ямар тунгаар уулгах ёстой вэ?

- А. 50 мг
- В. 100 мг
- С. 200 мг

- D. 500 мг
- E. 1000 мг

/284./ 70 настай өвгөн өөртөө үйлчлэх чадвартай тул өөрөө өглөөний цай ундаа уудаг ба өдөр өөртөө лапшаа, будаатай шөл мэтийн хөнгөн хоол хийж иддэг. Хоолны завсраар хааяа талх, боов иддэг. Өвгөнийг хүүхдүүд нь гэртэй орхиод өглөө бүр ажилдаа явдаг.

Оройн хоолыг хүүхдүүд нь хийдэг ба гэр бүлээрээ иддэг байв. Нэг өглөө өвгөн босоод өглөөний ундаа уух гэтэл ямар ч талх, боов, боорцог байсангүй. Будаа агшаах гэтэл будаа дууссан байв. Хөргөгчинд мах дууссан болохыг өвгөн анзаарч, 10 цагаас дэлгүүр онгойход дэлгүүр явж мах, будаа, талх авахаар шийдэв. Гэтэл түүнд маш бага мөнгө байсан тул тэр мах хямдхан бөөнддөг нилээд зайтай дэлгүүр явахаар шийдэв. Тэр 10 цаг болоход гэрээс гарч дэлгүүр зорьсон боловч, дэлгүүр 11 цагаас онгойв. Хүлээсээр байгаад дэлгүүрт орход махаа цавчихыг хүлээх болов. Тэр өглөөнөөс хойш юу ч идээгүй байсан тул ухаан нь орон гаран боллоо. Тэр гэртээ харих гэсэн боловч төөрчээ. Цагийн дараа өвгөн гудамжинд авцалдаагүй, дэмий юм ярж, зорчигчдыг харааж, үе үе чарлаж байв. Тэр яагаад дэмийрсэн бэ?

- A. Тэр тэнэгрэл зөнөгрөлтэй байсан тул.
- B. Шизофренистэй байсан тул
- C. Өлссөн ба цусны сахар багассан тул
- D. Хордлого болсон тул
- E. Баас хатсан тул.

/285./ 76 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Тэр шатаар явах үед амьсгааддаг байсан бол одоо тайван байх үедээ ч амьсгааддаг болсон. Орой болоход түүний хоёр шилбэ, шагайгаар хавансан байдаг. Шөнө босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв. Тэр ямар эмгэгтэй байх магадлалтай вэ?

- A. Чихрийн шижин
- B. Түрүү булчирхай томрох хам шинж
- C. Чихрийн бус шижин
- D. Зүрхний дутагдал, хаван шөнө бууснаас шээс шөнө элбэгшсэн байж болзошгүй
- E. Цистит

/286./ Өвчтөн А. 72 настай, бөөрний архаг үрэвсэлтэй ба үе үе ампициллин, амоксациллин, цефазолин, ципрофлоксацин уудаг. Гэтэл үмхий үнэртэй, салсархаг, хөөсөрхөг, заримдаа цусан судалтай суулгаж эхэлсэн ба хэвлийгээр бага зэрэг өвдөх шинж илэрч, энэ нь 10 хоногоос удаан үргэлжилсэн. Тэр ямар шалтгаантай суулгалт вэ?

- A. Дизентери буюу Клебсиеллын шалтгаантай
- B. Стафилококкийн шалтгаантай
- C. Clostridium difficile –ийн шалтгаантай
- D. Escherichia coli шалтгаантай
- E. Дисбактериозын шалтгаантай

/287./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөг рүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьегийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар өвчин байх магадлал илүү өндөр байна вэ?

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/288./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 10 оноо бол юу гэж үнэлэх вэ?

- A. Эрүүл, зовиургүй, өвчний шинжгүй

- B. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай
- C. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.
- D. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа
- E. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг.

/289./ Настан бусдаас хамааралгүй өөртөө үйлчлэх бүрэн чадвартай болохыг яаж мэдэх вэ?

- A. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 1
- B. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 6 ба түүнээс дээш
- C. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 5
- D. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 4
- E. Өдөр тутмын амьдралын үзүүлэлтийн нийлбэр 0-6

/290./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 70 оноо бол юу гэж үнэлэх вэ?

- A. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.
- B. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай боловч өвчний зарим шинжүүд илэрсэн.
- C. Өөрийгөө арчлах чадвартай боловч хэвийн үйл ажиллагаа явуулах чадваргүй
- D. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг
- E. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа

/291./ 64 настай эрэгтэй, элэгний хатууралтай, хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд сул шингэн тогтоогдсон тул Спиринолактон 3 сарын турш 100 мг-аар ууж, 2 сарын турш 200 мг-аар буюу 8 шахмалаар өглөө бүр уудаг болсон. Түүний асцит нэг хэсэг буурсан байснаа одоо дахин ихсэж эхлэв. Одоо ямар арга хэмжээ авах вэ?

- A. Спиринолактоныг 200- 300 мг-аар өглөө бүр уулгах
- B. 200 мг Спиринолактоныг 40 мг Фуросемидтэй хавсарч уулгах
- C. Фуросемид дангаар нь 40 мг-аар уулгах
- D. Фуросемид дангаар нь 80 мг-аар уулгах
- E. Парацентез хийх

/292./ 78 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 10% сийрэг болсон байгааг илрүүлсэн. Түүнд өрхийн эмч Кальц, Даминдэм бичиж өгсөн ба кальцаар баялаг тул сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэхийг зөвлөсөн. Тэр эмэгтэй залуугаасаа эхлээд чихэртэй байхуу, кофе уудаг байсан ба сүү, цагаан идээ хэрэглэж заншаагүй байв. Сүү, тараг хэрэглэж эхэлсэн өдрөөсөө тэр суулгаж, суулгалтанд Котримоксазол, Фталазол, Бифидум бактерин, Линекс зэргийг уусан боловч суулгалт намдахгүй 10 хоног. Тэр ямар шалтгаантай суулгасан бэ?

- A. Кальцийн бэлдмэл уусан тул
- B. Сүү нь муудсан тул суулгасан
- C. Лактазагийн дутагдалтай тул суулгасан
- D. Дисбактериоз болсон тул
- E. Д аминдэм суулгуулдаг тул

/293./ 74 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүний шээсний урсгал сул, бага багаар дүлж шээж байгаа, шээсэн хэрнээ давсанд шээс үлдэх мэт шинж илэрдэг ба заримдаа тэвчихэд хэцүү болдог гэж өгүүлсэн байв. Тэр ямар эмгэгтэй байх магадлалтай вэ?

- A. Чихрийн шижин
- B. Түрүү булчирхай томрох хам шинж
- C. Чихрийн бус шижин
- D. Зүрхний хаван шөнө бууснаас шээс элбэгшсэн байж болзошгүй
- E. Цистит

/294./ 69 настай эрэгтэйн тохой, өвдөгний арьсан дээр, чихний дотор талын арьсан дээр том гүвдрүүт боргоцой шиг ургацтай. Гүвдрүүг хаглахад аарц шиг цагаан зүйл гарна. Өвдөгний үеэр явахад өвдөг тул өвдөлт намдаахаар Ибупрофен уусан ба эмчид хандсан. Түүний шээсний шинжилгээнд оксалат, урат зэрэг давс ихээр илэрсэн. Түүнд ямар өвчин байх магадлал өндөр байна.

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит

D. Тулай

E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/295./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлэхэд Карновскийн индекс 100 оноо бол юу гэж үнэлэх вэ?

A. Эрүүл, зовиургүй, өвчний шинжгүй

B. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.

C. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай

D. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа

E. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг

/296./ 64 настай эрэгтэй, элэгний хатууралтай, хэвлийд асцит хуримтлагдсан нь цалгих шинжээр илэрсэн ба хэт авиан шинжилгээгээр хэвлийд 3 литр орчим сул шингэн тогтоогдсон. Түүнд одоогоор амьсгаадах, өвдөх шинж илрээгүй байна. Түүнд 100 мг-аар Спиринолактоныг өглөө бүр уулгаж эхэлсэн. 72 цагийн дараа хэвлийн тойргийг хэмжиж үзэхэд хэвлийн тойрог 108 см байсан бол 72 цагийн дараа 104 см болсон байв. Цаашид энэ өвчтөнд ямар арга хэмжээ авах вэ?

A. Эмчилгээг үргэлжлүүлэх

B. Спиринолактоныг 300 мг-аар уулгах

C. Фуросемид 40 мг-аар уулгах

D. Фуросемид 80 мг-аар уулгах

E. Парацентез хийх

/297./ 82 настай эмгэн насны доройтлын улмаас хэвтэрт орсон. Тэр зөнөсөн тул заримдаа ач нараа танихгүй, элдэв юм ярьдаг. Түүнийг хүүхдүүд нь хооллохгүй бол өөрөө хоолоо идэх, халбагдах чадваргүй болсон. Шээс нь задвайрсан тул нэг удаагийн живх хэрэглэдэг. Хувцасаа өмсөх чадвар муудсан, товчны нүхээ олдоггүй тул хүүхдүүд нь хувцасладаг. Түүний шээс өтгөн хүрэн өнгөтэй, өмхий үнэртэй байсан ба шээсний тестерт нитрат ихтэй гарсан байна. Бусад үзүүлэлтүүд хэвийн байв. Тэр ямар өвчтэй байх өндөр магадлалтай вэ?

A. Хатгалгаа

B. Үжил

C. Бөөр, шээсний замын халдвар

D. Хоолны хордлого

E. В вируссын гепатит

/298./ 88 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 25% сийрэг болсон байгааг илрүүлсэн ба түүний бүх биеийн яс янгинаж өвддөг зовиуртай тул гол төлөв хэвтэрт байдаг. Өвдөлт нь 2-3-р зэрэг. Түүнд бифосфонатын эмийн бүлгээс Кальцтай, Даминдэмтэй хамт хэрэглэхийг ямар тохиолдолд өрхийн эмч зөлөж болохгүй вэ?

A. Ясны өвдөлттэй

B. Бөөрний дутагдалтай

C. Ясны сийрэгжилт 20%-иас бага

D. Ясны эмгэг хугаралттай

E. Зүрхний дутагдалтай

/299./ Чихрийн шижингийн “дунд” зэрэг ямар хүндрэлтэй явагддаг вэ?

1. Чихрийн шижингийн ретинопатийн эрт үе

2. Чихрийн шижингийн нефропатийн микроальбуминурийн шат

3. Чихрийн шижингийн мэдрэлийн хүндрэл

4. Том судасны хүндрэлүүд

5. Зүрхний титэм судасны эмгэг

/300./ ХПВ-ийн шинжилгээ нь умайн хүзүүний өмөнг оношлоход ба эмчлэхэд туслах уу?

1. Папилловирусын халдвар байгааг 90% батлана.

2. Умайн хүзүүний өмөнг оношлоход ПАП шинжилгээтэй хамт хийх хэрэгтэй

3. ХПВ-ийн шинжилгээний хариу 2.5 цагийн дараа гардаг ба өртөг багатай тул үнэлгээ, эмчилгээг нэг өдөр хийх боломж олгодог

4. ХПВ-ийн шинжилгээ нь умайн хүзүүний өмөнг оношлоход туслахгүй тул ач холбогдолгүй

5. ХПВ-ийн шинжилгээ нь зөвхөн халдвар байгаа эсэхийг оношлох тул ач холбогдолгүй.

/301./ Хөх бэрсүүтэх эмгэгтэй эмэгтэйд ямар тусламж үйлчилгээ үзүүлэх вэ?

1. Уйланхайнаас цусархаг шингэн илэрвэл мэс засал хийлгэхээр шилжүүлнэ.

2. Хэт авиан шинжилгээгээр ердийн уйланхай илэрвэл агууламжаас соруулах аргаар сорьц авч шижлэнэ, хяналтанд авна.

3. Хэт авиан шинжилгээгээр хатуу цуллагтай гэмтэц илэрвэл хатуу үүсгэвэрийг эмчилдэгтэй ижил эмчилнэ.

4. Хөхний эмнэлзүйн ба маммографийн шинжилгээ хийх

5. Хэт авиан ба маммографийн шинжилгээгээр хэвийн бус эмгэг, арьс татагдах шинж илэрч, 2 сараас дээш хугацаанд аяндаа арилахгүй байвал шилжүүлнэ.

/302./ Өвдөлт намдаах үндсэн эмүүд гэж ямар эмүүд вэ?

1. Аспирин, Парацетамол, Трамадол

2. Таталтын эсрэг эм

3. Морфин

4. Гутралын эсрэг эм

5. Дексаметазон

/303./ 10-аас дээш жил Чихрийн шижин хэвшинж -2 той өвчтөнд ямар тохиолдолд 3 эм хавсарч хэрэглэх вэ?

1. Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

2. Хоёр эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 7\%$

3. Эмнэлзүйн шинж тэмдэг тод

4. Эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг

5. Гурван эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

/304./ АГ-тэй өвчтөнд эмэн эмчилгээ эхлэх заалт:

1. СД  $\geq 160$  мм МУБ, эсвэл ДД  $\geq 100$  мм МУБ

2. СД  $\geq 140$  мм МУБ, эсвэл ДД  $\geq 90$  мм МУБ боловч зүрх судасны өвчин, бөөрний өвчин, чихрийн шижинтэй, бай эрхтний гэмтэлтэй бол эмийн эмчилгээг эхлэх.

3. СД  $\geq 140$  мм МУБ, эсвэл ДД  $\geq 90$  мм МУБ боловч хувь хүний холестеролын хэмжээ өндөр ( $\geq 8$  ммоль/л) ба эрсдлийн түвшин  $\geq 20\%$  гарсан.

4. СД  $\geq 140$  мм МУБ, эсвэл ДД  $\geq 80$  мм МУБ

5. СД  $\geq 130$  мм МУБ, эсвэл ДД  $\geq 70$  мм МУБ

/305./ Хөхний өмөнг баталгаатай оношлох ямар аргууд байдаг вэ?

1. Оношлогооны маммограм

2. Соронзон давтамжит томографийн шинжилгээ

3. Цоргонд шингэн шахаж эсийн шинжилгээ авах

4. Өөрөө хөхөө шалгах

5. Эмчээр хөхний эмнэлзүйн шинжилгээ хийлгэх

/306./ Бөөрний үйл ажиллагааны алдагдалтай чихрийн шижинтэй өвчтөний менежментийн онцлогийг дурьдах:

1. Эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг ба глюкозжсон гемоглобин  $\geq 6.5\%$  бол 2 эм хавсарч хэрэглэнэ.

2. 2 эм хавсарч хэрэглэж байхад глюкозжсон гемоглобин  $\geq 6.5\%$  бол инсулин арьсан дор тарих.

3. Бөөрний дутагдалтай өвчтөнд гурван эм хавсарч хэрэглэхгүй.

4. Сульфаниламочевин хэрэглэхгүй

5. Богино хугацаатай инсулин хэрэглэхгүй

/307./ Умайн хүзүүний өмөн үүсэх магадлалыг нэмэгдүүлдэг ямар эрсдэлт хүчин зүйлс байдаг вэ?

1. Бэлгийн харьцаанд эрт буюу 18 наснаас өмнө орох

2. БЗДХ

3. Хэт залуу насандаа жирэмслэх ба төрөх

4. Тамхидалт

5. Жирэмсэн үедээ зулбалтаас сэргийлж диэтилстилбестрол даавар хэрэглэх

/308./ Арьсаар нэвчдэг Фентанилын наадаг туузын давуу тал юу вэ?

1. Өвдөлт намдаах үйлчилгээ 72 цаг буюу 3 хоног.

2. Эм уух чадваргүй, нарийнтсан эсвэл уусан болгоноо бөөлждөг өвчтөнд хэрэглэхэд хамгийн тохиромжтой.

3. Амьсгал дарангуйлах, өтгөн хатаах гаж үйлчилгээ багатай.

4. Морфинаас 80-100 дахин хүчтэй тул 100 дахин бага тунгаар хэрэглэдэг.



5. Өвчтөнийг тарих, хатгах, олон эм уулгах шаардлагагүй, зөвхөн наах тул давуу талтай.  
/309./ Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ гэж юу вэ?

1. Өвчний улмаас тавилан муутай болсон өвчтөний амьдралын чанарыг дээшлүүлдэг тусламж үйлчилгээ.

2. Өвчний улмаас тавилан муутай болсон өвчтөний гэр бүлийнхний амьдралын чанарыг дээшлүүлдэг тусламж үйлчилгээ.

3. Өвчний улмаас тавилан муутай болсон өвчтөнд ба ар гэрийнхэнд үзүүлдэг багц /эмчилгээ, асаргаа, сэтгэл засал, нийгмийн халамж, сүсэг бишрэлийн тусламж, сургалт, бодлого/ тусламж үйлчилгээ.

4. Эмчилгээгүй болсон хүнийг удаан зовоохгүйн тулд үхлийг хурдасгадаг үйлчилгээ.

5. Ямарч өвчтөний эмчилгээний зардлыг төлж, хөнгөвчилдөг үйлчилгээ.

/310./ 10-аас доош жил Чихрийн шижин хэвшинж -2 той өвчтөнд ямар тохиолдолд инсулин арьсан дор тарьж хэрэглэх вэ?

1. Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

2. Эмнэлзүйн шинж тэмдэг тод

3. Эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг

4. Гурван эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

5. Хоёр эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

/311./ Артерийн гипертенз гэж юуг хэлэх вэ?

1. 4-6 удаагийн хэмжилтээр СД 140 мм МУБ буюу түүнээс дээш, ДД 90 мм МУБ буюу түүнээс дээш хэмжээнд байхыг Артерийн Гипертензи гэнэ.

2. СД 160 мм МУБ буюу түүнээс дээш, ДД 100 мм МУБ буюу түүнээс дээш хэмжээнд байхыг Артерийн Гипертензи гэнэ.

3. Даралт бууруулах эм ууж байгаа бол АД хэвийн байсан ч Артерийн Гипертензи гэнэ.

4. СД 200 мм МУБ буюу түүнээс дээш, ДД 100 мм МУБ буюу түүнээс дээш хэмжээнд байхыг Артерийн Гипертензи гэнэ

5. 4-6 удаагийн хэмжилтээр СД 120 мм МУБ буюу түүнээс дээш, ДД 60 мм МУБ буюу түүнээс дээш хэмжээнд байхыг Артерийн Гипертензи гэнэ.

/312./ Өөрөө хянах боломжтой хөхний өмөнгийн эрсдэлт хүчин зүйлсийг хэрхэн багасгах вэ?

1. 30 хүртлэх насандаа жирэмслэх, олон хүүхэд төрүүлэх

2. Хүүхдээ хөхөөр хооллох

3. Жирэмснээс хамгаалах эм хэрэглэхгүй байх

4. Архи хэрэглэхгүй байх

5. Таргалалтаас сэргийлж, жингээ багасгах ба дасгал хөдөлгөөн хийх

/313./ Умайн хүзүүний өмөнгөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ямар хүн амыг зорилтот бүлэг болгох вэ?

1. 30,33,36,39 насны эмэгтэйчүүд

2. 42,45,48, 51 насны эмэгтэйчүүд

3. 54,57,60 насны эмэгтэйчүүд

4. 16,19,22 насны эмэгтэйчүүд

5. 25,28,31 насны эмэгтэйчүүд

/314./ Жирэмсний эхний 3 сард буй хөхний өмөнтэй эмэгтэйд үзүүлэх тусламжийн алгоритмыг тайлбарлах:

1. Жирэмснийг таслах талаар ярилцаж, шийдвэр гаргах

2. Хэрэв жирэмснийг үргэлжлүүлэх бол хөх авах, сугны булчирхайн өөрчлөлтийг үндэслэж үе шатыг тогтоох.

3. Мэс заслын дараах хими эмчилгээг жирэмсний 2 дугаар гурван сард эхлүүлэх.

4. Мэс заслын дараах туяа эмчилгээг төрсний дараа эхлэх.

5. Мэс заслын дараах дааврын эмчилгээг төрсний дараа эхлэх.

/315./ Морфин хэрэглэж буй өмөнтэй өвчтөнд илэрч болзошгүй морфины гаж үйлчилгээ:

1. Амьсгал дарангуйлах

2. Өтгөн хатах

3. Дотор муухайрч бөөлжих

4. Нойрмог болж унтаархах

5. Дэмийрэх

/316./ ПАП шинжилгээний хариу хэвийн бус буюу тодорхой хэв шинжгүй хавтгай эсүүд (ASC-US) гарсан ба ХПВ-ийн шинжилгээ эерэг гарвал яах ёстой вэ?

1. Үтрээний дурангийн ба эдийн шинжилгээ хийнэ.
2. Үтрээний дуран ба эдийн шинжилгээгээр өмөн илрээгүй бол 12 сарын дараа эсзүйн шинжилгээг давтана.
3. Үтрээний дуран ба эдийн шинжилгээгээр өмөн илэрсэн бол өмөнгийн удирдамжийг мөрдөнө.
4. Эс зүйн шинжилгээг 4-6 сарын дараа давтана.
5. ХПВ-ийн ДНХ-ийн шинжилгээг 3 сарын дараа давтана.

/317./ Глюкозын шинжилгээгээр ямар өөрчлөлттэй байвал чихрийн шижинтэй гэж тооцох вэ?

1. Өлөн үед глюкоз тодорхойлох шинжилгээгээр 5.6-6.0 ммоль/л
2. Өлөн үед глюкоз  $\geq 6.1$  ммоль/л
3. Өлөн биш үед глюкоз тодорхойлох шинжилгээгээр глюкоз 7.8-11.0 ммоль/л
4. Өлөн биш үед ба глюкозын ачаалалтай сорилоор глюкоз  $\geq 11.1$  ммоль/л
5. Глюкозын ачаалалтай сорилоор глюкоз 7.8-11.0 ммоль/л

/318./ Хөхний эмнэлзүйн шинжилгээг хийх дээ хөхийг ямар байрлалд хэрхэн тэмтэрч шалгах вэ?

1. Дал нь доор дэр эвж хэвтүүлнэ. Дэр эвсэн талын гарыг толгойн доор нь тавьж дэрлүүлнэ.
2. Долоовор, дунд, ядам хурууны алган талын гадаргуугаар тойрог маягийн хөдөлгөөн хийж тэмтрэнэ.
3. Хөхийг эгэмнээс хөхний доод нугалаас хүртэл, суганы голын шугамнаас өвчүү хүртэл хөхийг бүхэлд нь мөн тунгалгын булчирхай, сугыг хамруулан тэмтэрч шалгана.
4. Хөхийг 3 удаа тэмтэрч шалгах ба эхний удаан хөнгөн, хоёр дахь удаа зунд зэрэг, гурав дахь удаа хүчтэй дарж тэмтрэлтийг гүйцэтгэнэ.
5. Хэвийн бус өөрчлөлт илрүүлбэл нөгөө хөхтэй харьцуулан тэмтрэнэ.

/319./ АГ-тэй өвчтөнд заавал хийх шинжилгээнүүд:

1. Өлөн үеийн цусны глюкоз
2. Липидын үзүүлэлтүүд
3. Цусан дахь кали, натри, креатинин, шээсний хүчил, креатинины клиренс
4. Цус, шээсний ерөнхий шинжилгээ
5. Зүрхний цахилгаан бичлэг

/320./ Өвдөлт намдаахаар морфиныг хэрэглэж эхлэх заалт юу вэ?

1. Өвчтөн 1-2-р зэргийн өвдөлттэй.
2. Өвчтөн 7-10-р зэргийн өвдөлттэй
3. 1-р шатны эмчилгээнд үр дүнгүй байх
4. 2-р шатны эмчилгээнд үр дүнгүй байх
5. Диклоденк лаагаар үйлчлэхгүй байх

/321./ Өөрөө хянах боломжгүй хөхний өмөнгийн эрсдэлт хүчин зүйлсийг тоочих:

1. Нас, ген
2. Гэр бүлийн эрүүл мэндийн байдал
3. Өмнө нь цацраг туяанд өртөж байсан
4. Биений юм 12 хүртлэх насанд эхэлсэн эсвэл 55 наснаас хойш цэвэршсэн
5. Диэтилстильбэстрол эмчилгээг жирэмсэн байхдаа үр зулбахаас сэргийлж ууж байсан

/322./ ПАП шинжилгээний хариу хэвийн бус буюу тодорхой хэв шинжгүй хавтгай эсүүд (ASC-US) гарсан үед яах ёстой вэ?

1. Эс зүйн шинжилгээг 4-6 сарын дараа давтана.
2. ХПВ-ийн ДНХ-ийн шинжилгээ хийнэ.
3. Үтрээний дурангийн ба эдийн шинжилгээ хийнэ.
4. Эс зүйн давтан шинжилгээ сөрөг гарвал эс зүйн шинжилгээг 4-6 сарын дараа давтана.
5. Үтрээний дуран ба эдийн шинжилгээгээр өмөн илрээгүй бол 12 сарын дараа эсзүйн шинжилгээг давтана

/323./ Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэлт буюу хоёрдогч урьдчилан сэргийлэлтийг хэрхэн хийх вэ?

1. ABC (А тэвч, В үнэнч бай, С бэлгэвч хэрэглэ) зарчим баримталж бэлгийн харьцааг эрүүлжүүлэх

2. ПАП шинжилгээ хийх

3. ХПВ –ын 16,18-р омгийн эсрэг вакцинжуулах

4. Цууны хүчлийн сорил тавьж, харж оношлох

5. Жирэмсэн үедээ зулбалтаас сэргийлж диэтилстилбестрол даавар хэрэглэхээс сэргийлэх

/324./ Умайн хүзүүний өмөн үүсэх магадлалыг нэмэгдүүлдэг ямар эрсдэлт хүчин зүйлс байдаг вэ?

1. Бэлэг эрхтэний хомхой

2. Дархлааны тогтолцоо сулрах

3. Олон хавьтагчтай бэлгийн харьцаанд орох

4. Замбараагүй ба хэвийн бус (ам, анус) бэлгийн харьцаа үүсгэх

5. Жирэмснээс хамгаалах бэлдмэл 5 ба түүнээс дээш жил хэрэглэх

/325./ Удаан үйлчилгээтэй Морфиныг 30 мг-аар 12 цагаар байнгын өвдөлт намдаахаар тогтмол цагаар хэрэглэж байгаа боловч өвдөлт сэдэрвэл сэдэрсэн өвдөлтийг намдаах зорилгоор ямар эм, ямар тунгаар авах ёстой вэ?

1. Богино үйлчилгээтэй Морфиныг сэдэрсэн өвдөлт намдаахаар хэрэглэнэ. Байнгын өвдөлт намдаах Морфины хоногийн тунгийн 5-15 хувийг сэдэрсэн өвдөлт намдаахаар хэрэглэнэ.

2. Удаан үйлчилгээтэй Морфиныг 5 мг-аар сэдэрсэн өвдөлт намдаахаар хэрэглэнэ.

3. Өвдөлт сэдэрсэн үед богино үйлчилгээтэй Морфиныг 5 мг-аар 1 цагаас ойргүй уулгах ба 4-өөс олон сэдэрвэл эмчид үзүүлж, байнгын өвдөлт намдаах тунг ихэсгэх.

4. Өвдөлт сэдэрсэн үед Трамадол 50 мг-аар тарих.

5. Өвдөлт сэдэрсэн үед Морфин 1 ампулаар тарих.

/326./ Хорт хавдартай өвчтөнд өвдөлт намдаах эмийг тогтмол цагаар хэрэглэх нь ямар ашигтай вэ?

1. Хорт хавдрын өвдөлт ихэнхи тохиолдолд архаг байнгын байдаг, гэтэл өвдөлт намдаах эм тодорхой цагаар үйлчилдэг тул эмийн үйлчилгээ дуусахад өвдөлт дахин сэдрэх аюултай тул эмийг цагаар хэрэглэх нь ашигтай

2. Хорт хавдартай өвчтөнд тэсхийн аргагүй өвдсөн үед нь өвдөлт намдаах эм өгөх нь дээр

3. Байнгын архаг өвдөлттэй өвчтөнд эмийг тогтмол цагаар өгөөгүйгээс өвдөлт сэдрэх, өвдөлтийн босго багасах, эмийн эхний тунд намдахаа болих аюултай тул цагаар хэрэглэх нь ашигтай

4. Өвдөлт намдаах эмийг цагаар хэрэглэхэд гаж үйлчилгээ илрэхгүй

5. Өвдөлт намдаах эмийг цагаар хэрэглэхэд гаж үйлчилгээ илэрдэг

/327./ Хоёрдогч буюу бусад хэлбэрийн чихрийн шижин ямар шалтгаанаар үүсдэг вэ?

1. Инсулины шүүрлийн ба үйлчлэлийн удамшлын гажуудал

2. Нойр булчирхайн эмгэгүүд

3. Эмийн бэлдмэл ба химийн бодис

4. Халдвар

5. Дотоод шүүрлийн эмгэгүүд

/328./ 10-аас дээш жил Чихрийн шижин хэвшинж -2 той өвчтөнд ямар тохиолдолд 2 эм хавсарч хэрэглэх вэ?

1. Глюкозжон гемоглобин  $\geq 7\%$

2. Эмнэлзүйн шинж тэмдэг тод

3. Эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг

4. Хоёр эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

5. Гурван эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

/329./ 10-аас дээш жил Чихрийн шижин хэвшинж -2 той өвчтөнд ямар тохиолдолд инсулин арьсан дор тарих вэ?

1. Эмнэлзүйн шинж тэмдэг тод

2. Эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг

3. Гурван эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 7-7.5\%$

4. Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

5. Хоёр эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

/330./ 10-аас доош жил Чихрийн шижин хэвшинж -2 той өвчтөнд ямар тохиолдолд 3 эм хавсарч хэрэглэх вэ?

1. Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$
  2. Эмнэлзүйн шинж тэмдэг тод
  3. Эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг
  4. Хоёр эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$
  5. Гурван эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$
- /331./ Хөхний өмөнтэй эмэгтэйд дааврын эмчилгээ хийх алгоритмыг тайлбарлах:
1. Эстрогены авуур ба прогестероны авуур эерэг бол даавар эмчилгээ хийнэ.
  2. Эмэгтэй цэвэршихийн өмнөх үед байвал Тамоксифен 5 гаруй жил хэрэглэнэ.
  3. Эмэгтэй цэвэршсэний дараах үед байвал Ароматазыг саатуулагчийг 5-аас дээш жил хэрэглэх., мөн Тамоксифеныг 5-аас дээш жил хэрэглэх.
  4. Дексаметазон тарих.
  5. Дексаметазон 5-аас дээш жил уулгах
- /332./ Хөхний эмнэлзүйн шинжилгээг хийх дээ хөхийг ямар байрлалд харж шалгах вэ?
1. Гараа унжуулж зогсох
  2. Гараа ташаан дээрээ хүчтэй тулж урагш бөхийж зогсох
  3. Хоёр гараа толгой дээрээ өргөж зогсох
  4. Хоёр гараараа элгээ тэвэрч зогсох.
  5. Хоёр гараараа хөхөө өргөж бариад харах.
- /333./ Ямар өвчний үед архаг өвдөлт илүүтэй тохиолдох вэ?
1. Гэмтлийн үед
  2. Хорт хавдрын үед
  3. Хагалгааны дараа
  4. Үе мөчний ба системний өвчний үед
  5. Жижиг мэс ажилбарын дараа
- /334./ ХСҮ дээр умайн хүзүүний өмөнтэй эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Өмөнгийн эсрэг өвөрмөц эмчилгээ хийнэ
  2. Умайн хүзүүний эдзүйн шинжилгээ хийнэ
  3. Хөнгөвчлөх эмчилгээ хийнэ
  4. Эрсдэлт хүчин зүйлийг бууруулах зөвлөгөө өгнө
  5. ХПВ-ын эсрэг эмчилгээ хийнэ.
- /335./ ПАП шинжилгээг хэрхэн хийх вэ?
1. Үтрээнд толь тавиад умайн хүзүүг нүдэнд харахаар ил болгоно.
  2. Умайн хүзүүнээс хусах юмуу сойзоор эсийн түрхэц авч шинжилгээний шилэн дээр түрхэнэ
  3. ПАП түрхэцээ лабораторт илгээж, лабораторт дурандаж шинжилнэ.
  4. Цууны хүчлийн 3-5%-ийн уусмалыг умайн хүзүүнд түрхэнэ.
  5. Цайрч харагдаж буй эд эс нь умайн өмөн байх магдлалтай гэж дүгнэнэ.
- /336./ Глюкозын шинжилгээгээр ямар өөрчлөлттэй байвал чихрийн шижингийн урьдал үе гэж тооцох вэ?
1. Өлөн үед глюкоз тодорхойлох шинжилгээгээр 5.6-6.0 ммоль/л
  2. Өлөн биш үед глюкоз тодорхойлох шинжилгээгээр глюкоз 7.8-11.0 ммоль/л
  3. Глюкозын ачаалалтай сорилоор глюкоз 7.8-11.0 ммоль/л
  4. Өлөн үед глюкоз  $\geq 6.1$  ммоль/л
  5. Өлөн биш үед ба глюкозын ачаалалтай сорилоор глюкоз  $\geq 11.1$  ммоль/л
- /337./ Хөхнөөс шүүрэл гарах эмгэгтэй эмэгтэйд ямар тусламж үйлчилгээ үзүүлэх вэ?
1. Хөхний эмнэлзүйн ба маммографийн шинжилгээ хийх
  2. Олон суваг хамарсан хэвийн бус эмгэг үүсгэвэртэй ба маммограм дээр эмгэг өөрчлөлттэй бол мэргэжлийн эмчид шилжүүлнэ
  3. Нэг суваг хамарсан эмгэг өөрчлөлттэй бол суваг тайрах мэс засал хийлгүүлхээр шилжүүлнэ.
  4. Туяа эмчилгээнд явуулах.
  5. Хими эмчилгээнд явуулах.
- /338./ Хөхний өмөнг эрт илрүүлэх ямар энгийн арга арга байдаг вэ?
1. Өөрөө хөхөө шалгах арга
  2. Хөхний өмөнгийн маркер үзэх
  3. Эмчээр хөхний эмнэлзүйн шинжилгээ хийлгэх

4. Маммографин шижилгээ хийх
5. Эсийн шинжилгээ

/339./ Хөхний өмөн үүсэх шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг тоочих:

1. Ээж, эгч, дүүс хөхний өмөнгөөр өвдсөн
2. Анх жирэмсэлсэн нас эрт байх
3. Жирэмслэлтийн ба төрөлтийн тоо цөөн
4. Архи, тамхи хэрэглэдэг
5. Фиброаденоз, зангилаат аденоз, хатууралт аденозоор өмнө нь өвдөж байсан.

/340./ Сум, өрхийн эмнэлгүүд ПАП шинжилгээгээр эрт илрүүлэлтийг хэрхэн хийх вэ?

1. Долоо хоногийн хоёр өдрийг эрт илрүүлэлтийн шинжилгээ хийхээр товлон
2. Сум, өрхийн эмнэлгүүд нь эрт илрүүлэлт хийх өдрийн хуваарийг ил харагдах газар бичиж байрлуулна
3. Илрүүлэх үзлэгт хамрагдсан бүх эмэгтэйчүүдээс ПАП шинжилгээг тусгайлан бэлтгэгдсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн ажилтан авна (ЭЭМА).
4. ЭЭМА нь үзлэгийн хуудсыг бөглөөд үйлчлүүлэгчид өгнө. Эмэгтэйн мэдээллийг тусгай бүртгэлд авч хадгална.
5. АНЭ, ДЭМНд ПАП тест уншидаг болтол эдзүйн шинжилгээг ХСҮТ-д явуулж, тэнд уншиж, хариуг өгнө.

/341./ Умайн хүзүүний өмөнгийн анхдагч урьдчилан сэргийлэлтийг хэрхэн хийх вэ?

1. ABC (А тэвч, В үнэнч бай, С бэлгэвч хэрэглэ) зарчим баримталж бэлгийн харьцааг эрүүлжүүлэх
2. ХПВ –ын 16,18-р омгийн эсрэг вакцинжуулах
3. Эрүүл мэндийн боловсрол олгох ба эрүүл зан үйлийг хэвшүүлэх
4. Жирэмсэн үедээ зулбалтаас сэргийлж диэтилстилбестрол даавар хэрэглэхээс сэргийлэх
5. Жирэмснээс хамгаалах бэлдмэл хэрэглэхгүй байхыг зөвлөх

/342./ АГ-ийн үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлүүдийг дурьдах:

1. Давсны хэрэглээ
2. Тамхины хэрэглээ ба архины хэрэглээ
3. Илүүдэл жин ба таргалалт
4. Зохисгүй хооллолт
5. Хөдөлгөөний хомсдол

/343./ Монголд ямар төрлийн морфин байдаг вэ?

1. Богино /4-6 цаг/ үйлчилгээтэй уудаг морфин 10 мг-ын шахмалаар
2. Удаан /8-12 цаг/ үйлчилгээтэй уудаг морфин 30 мг-ын шахмалаар
3. Морфин тарих уусмалаар 1%-ын 1мл туншилтэй
4. Арьсан дээр наахад 72 цаг өвдөлт намдаадаг тууз хэлбэрээр
5. Хүүхдэд зориулсан 1%-ын сиропын уусмалаар

/344./ Хорт хавдартай өвчтөнд өвдөлт намдаах эмийг уухаар хэрэглэх нь ямар ашигтай вэ?

1. Хорт хавдартай өвчтөний өвдөлт ихэнхи тохиолдолд архаг байнгын өвдөлт байдаг тул эмийг уухаар хэрэглэх нь дээр
2. Хорт хавдартай өвчтөний өвдөлт ихэнхи тохиолдолд цочмог өвдөлт байдаг тул уухаар хэрэглэх нь дээр.
3. Архаг байнгын өвдөлттэй хүний өвдөлтийг тариагаар намдаах нь хэдэн сараар тарих гэсэн үг тул процедурын өвдөлтийг нэмэх аюултай тул эмийг уулгах нь дээр
4. Хавдрын цочмог өвдөлт нь богино хугацаагаар үргэлжилдэг тул цөөн хоног тарих нь дээр.
5. Эмийг уухаар хэрэглэхэд гаж үйлчилгээ багатай

/345./ Чихрийн шижин хэвшинж2-ийн шалтгаан, эмгэг жам, эмчилгээний зарчмыг сонгох:

1. Инсулины мэдрэг чанар буурах шалтгаантай
2. Амьдралын хэв маяг өөрчлөх ба бигуанидын бүлгийн эмийн эмчилгээ
3. Бигуанидын 3 эмийг хавсарч хэрэглэхэд үр дүнгүй бол Инсулин эмчилгээ
4. Аутоиммуны шалтгаантай
5. Лангергансын арлын бета эсийн аутоиммуны гэмтэл

/346./ Чихрийн шижинтэй өвчтөнд өөрчилж болох эрсдэлт хүчин зүйлийг дурьдах:

1. Илүүдэл жин

2. Хөдөлгөөний хомсдол
3. Зохисгүй хооллолт
4. Архи, тамхины хэрэглээ
5. Глюкоз ихэсгэдэг эмийн хэрэглээ (Глюкокортикоид)

/347./ Анхан шатны өрх, сумын эмч нар, багийн баг эмч нар хөхний эмнэлзүйн шинжилгээгээр бэрсүү сөрөх гарсан эмэгтэйд ямар менежмент хийх вэ?

1. 3 жилийн дараа хөхний эмнэлзүйн шинжилгээг давтах.
2. Хоёрдугаар шатлалд явуулах.
3. Өндөр эрсдэлтэй эмэгтэй байвал жил тутам маммографиний шинжилгээ хийх.
4. Эдийн шинжилгээ хийх.
5. Хэт авиан шинжилгээ хийх.

/348./ Хөхөөр өвдөх эмгэгийн оношлогоо эмчилгээний алгоритмыг тайлбарлах.

1. Хөхний үүсгэвэрийг шинжилгээгээр үгүйсгэнэ.
2. Өвдөлт мөчлөгтэй холбоотой эсэхийг мөн өвдөлтийн зэргийг тогтооно.
3. Хүнд зэргийн өвдөлт мөчлөгтэй холбоотой ба зангилаа илэрсэн бол нэгдүгээрт Гамолений хүчил, хоёрдугаарт Даназол буюу Бромокриптин хэрэглэнэ. Эмчилгээнд үр дүнгүй бол мэргэжлийн эмчид шилжүүлнэ.

4. Хөнгөн ба дунд зэргийн өвдөлт мөчлөгтэй холбоотой ба зангилаа илэрсэн бол тайвшруулна.

5. Тархмал хүнд зэргийн өвдөлт мөчлөгтэй холбоогүй илэрсэн бол нэгдүгээр эгнээнд ҮЭСБЭМ хэрэглэнэ, хоёрдугаар эгнээнд Гамолений хүчил, Даназол буюу Бромокриптин хэрэглэнэ

/349./ Хөхийг хэвтээгээрээ яаж шалгах вэ?

1. Баруун мөрөн доор дэр байрлуулна.
2. Баруун гараа толгойн доороо тавьж дэрлэж хэвтэнэ.
3. Зүүн гараараа баруун хөхөө бүхэлд нь 2-4 –р хурууны алган талын гадаргуугаар жижиг тойрог хийж тэмтэрч шалгах.
4. Хөхний товчийг шахаж, ялгарал гарч байгаа эсэхийг шалгана.
5. Зүүн хөхийг дээрхийн адил хэвтээд, баруун гараар зүүн хөхийг шалгана.

/350./ ДЭМБ-ын зөвлөж буй үр дүнтэй бөгөөд үнэ өртөг багатай өмөнтэй өвчтөний өвдөлтийг намдаах 5 зарчим:

1. Өвдөлт намдаах эмийг уухаар хэрэглэх
2. Эмийг цагаар хэрэглэх
3. Эмийг үе шаттай хэрэглэх
4. Эмийг хувь хүнд тохируулан хэрэглэх
5. Эмийг бүх зүйлийг харгалзан хэрэглэх

/351./ 10-аас доош жил Чихрийн шижин хэвшинж -2 той өвчтөнд ямар тохиолдолд 2 эм хавсарч хэрэглэх вэ?

1. Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$
2. Эмнэлзүйн шинж тэмдэг тод
3. Эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг
4. Хоёр эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$
5. Гурван эм хавсарч хэрэглэж байгаа боловч Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$

/352./ Глюкозын шинжилгээгээр ямар өөрчлөлттэй байвал чихрийн шижингүй, хэвийн гэж тооцох вэ?

1. Өлөн үед глюкоз тодорхойлох шинжилгээгээр  $\leq 5.6$  ммоль/л
2. Өлөн биш үед глюкоз тодорхойлох шинжилгээгээр глюкоз  $\leq 7.8$  ммоль/л
3. Глюкозын ачаалалтай сорилоор глюкоз  $\leq 7.8$  ммоль/л
4. Өлөн үед глюкоз  $\geq 6.1$  ммоль/л
5. Өлөн биш үед ба глюкозын ачаалалтай сорилоор глюкоз  $\geq 11.1$  ммоль/л

/353./ Хөхний өмөнгийн үед илрэх шинжүүдийг тоочих:

1. Хөхөнд хүрэхэд халуун байх
2. Хөхний толгой дотогш татагдаж хонхойх
3. Хөхний арьс улайх, өөрчлөгдөх, татагдаж, жүржний хальс шиг харагдах
4. Хөхнөөс ялгарал, тунгалаг, цусархаг шүүс гарах

5. Биений юмны мөчлөгтэй холбоогүйгээр хөхний хэмжээ гэнэт томрох, хөх өвдөх, эмзэглэлтэй болох

/354./ ДЭМН, АНЭ буюу 2-р шатлал, БОЭТ буюу 3-р шатлалд умайн хүзүүний өмөнгөөс урьдчилан сэргийлэх ба эрт илрүүлэх зорилгоор ямар үйл ажиллагаа хийх вэ?

1. Пап шинжилгээ хийнэ
2. Үтрээн дурангаар шинжлэнэ
3. Эдзүйн шинжилгээ авах, хөлдөөх, цахилгаан гогцоогоор өөлөх ажилбар хийнэ
4. Хорт хавдрын өвөрмөц эмчилгээ хийнэ
5. Умайн хүзүүний эдзүйн шинжилгээ хийнэ

/355./ Цууны хүчлийн сорилыг хэрхэн хийх ба ямар ач холбогдолтой вэ?

1. Цууны хүчлийн 3-5%-ийн уусмалыг ашигладаг
2. Эсийн цитоплазмтай нь харьцуулахад том бөөмтэй гаж хувирлын эсүүд нь цууны хүчлийн сорилоор цайрч харагддаг тул эрт илрүүлэх ач холбогдолтой
3. Хэрэв эмгэг илэрвэл сорил хийлгэсэн даруйдаа эмчилгээ хийлгэж болдог ач холбогдолтой.
4. 35-45 насны эмэгтэйчүүдэд илүү ач холбогдолтой.
5. Шилжилтийн бүс умайн хүзүүний гадна талд байгаа тохиолдолд оношлогооны ач холбогдолтой.

/356./ Умайн хүзүүний өмөнгийн үед ямар эмнэлзүйн шинжүүд илэрч болох вэ?

1. Өмөнгийн хөгжлийн эрт үед ямар ч шинж илрэхгүй.
2. Хожуу шатанд биеийн юмны мөчлөгийн хооронд цус гарах
3. Бэлгийн харьцаа, үтрээний угаалга ба дотуур үзлэг хийсний дараа цус гарах
4. Биеийн юм хэвийнхээс удаан хугацаанд их хэмжээтэй ирэх
5. Аарцгийн хөндийн гүнд эсвэл бэлгийн харьцааны үед өвдөх

/357./ АГ-ийн урьдчилан сэргийлэлт ба эмчилгээнд амьдралын ямар хэв маягийг өөрчлөх нь чухал вэ?

1. Давсны Хэрэглээг хоногт 2гр хүртэл бууруулах
2. Эслэг ихтэй хоол хүнс хэрэглэх, амьтны гаралтай өөх тосны хэрэглээг багасгах, өдөрт 5 нэгж буюу 300-400 гр жимс ногоо хэрэглэх ба ургамлын гаралтай тос хэрэглэх.
3. Архины хэрэглээг хязгаарлах, хэрэв архиуудаг болэрэгтэйчүүд өдөрт 20-30 гр, эмэгтэйчүүд 10-20 гр-аас хэтрүүлэлгүй хэрэглэх.
4. Биеийн жинг бууруулах, БЖИ –ийг 18.5-25 хүртэл байлгахыг хичээх, бүсэлхийн тойргийн хэмжээг эрэгтэйчүүд 90 см, эмэгтэйчүүд 80 см –ээс бага байлгахыг хичээх.
5. Идэвхитэй хөдөлгөөн хийх, өдөрт 30-45 минутын дасгал тогтмол хийх. Тамхинаас гарах.

/358./ Трамадол нь эмийн ямар бүлэгт хамрах вэ?

1. Опиоид эмийн бүлэгт хамрана.
2. Стероид бус өвдөлт намдаах эм.
3. Өвдөлт намдаах 2-р шатанд хэрэглэх опиоид эмийн бүлэгт хамрана.
4. Хүчтэй өвдөлт намдаах опиоид эмийн бүлэгт хамрана
5. Өвдөлт намдаах туслах эмийн бүлэгт хамрана.

/359./ Чихрийн шижингийн “хүнд” зэрэг ямар хүндрэлтэй явагддаг вэ?

1. Чихрийн шижингийн ретинопатийн нэвчдэст үе
2. Чихрийн шижингийн нефропати ба бөөрний архаг дутагдал
3. Чихрийн шижингийн мэдрэлийн хүндрэл
4. Том судасны хүндрэлүүд ба захын судасны эмгэг
5. Зүрхний титэм судасны эмгэг

/360./ Чихрийн шижин хэвшинж1-ийн шалтгаан, эмгэг жам, эмчилгээний зарчмыг сонгох:

1. Аутоиммуны шалтгаантай
2. Лангергансын арлын бета эсийн аутоиммуны гэмтэл
3. Инсулин эмчилгээ
4. Инсулины мэдрэг чанар буурах шалтгаантай
5. Амьдралын хэв маяг өөрчлөх ба бигуанидын бүлгийн эмийн эмчилгээ

/361./ Чихрийн шижин хэвшинж -2 той өвчтөнд Глюкозжон гемоглобин  $\geq 6.5\%$  бол хавсран хэрэглэх эмийг тоочих:

1. Меглитидин

2. ДПП-4 хориглогч
3. Тиазолидиноид
4. Сульфанилмочевин
5. Бигуанидын бүлгийн эм

/362./ Жирэмсний 2 дахь 3 дахь гурван сарын эхэн үед буй хөхний өмөнтэй эмэгтэйд үзүүлэх тусламжийн алгоритмыг тайлбарлах:

1. Суганы булчирхайн өөрчлөлтөөр үе шатыг тогтоон хөх авах эсвэл хөх хадгалах мэс засал хийх

2. Мэс заслын өмнө хими эмчилгээ хийнэ
3. Төрсний дараа суганы булчирхайн өөрчлөлтөөр үе шатыг тогтооно.
4. Мэс заслын дараа хими эмчилгээг төрсний дараа хийнэ.
5. Мэс заслын дараах туяа ба даавар эмчилгээг төрсний дараа хийнэ.

/363./ Өвдөлт намдаах туслах эмүүдийг дурьд:

1. Дексаметазон
2. Таталтын эсрэг эм (Габалентин, Карбамазепин)
3. Амитриптилин
4. Аспирин
5. Трамадол

/364./ Өмөнтэй өвчтөнд өвдөлт үүсэх шалтгаан:

1. Өмөнгийн үсэрхийлэл эд эсийг нэвчих, дарах, цусан хамгамжийг алдагдуулснаас өвдөх
2. Хагалгааны дараах хурц өвдөлт
3. Хими, цацраг эмчилгээний дараа яс сийрэгжин өвдөх
4. Цацраг эмчилгээний дараа түлэгдсэн арьс салст өвдөх
5. Өтгөн хатаж хэвлийгээр өвдөх, асцитын шингэнд хэвлий цардайж өвдөх, шээс хаагдахад давсаг чинэрч өвдөх

/365./ 10-аас доош жил Чихрийн шижин хэвшинж 2 шинээр оношлогдсон бол ямар менежмент хийх вэ?

1. Амьдралын хэв маягийг үнэлэх ба өөрчлөх
2. Бигуанидын бүлгийн эмийн эмчилгээ хийх
3. 3-6 сарын турш эмчилгээний үр дүнг тооцох
4. Инсулин эмчилгээ хийх
5. Холимог инсулиныг арьсан доор тарих

/366./ Хөх хавагнах эмгэгийн оношлогоо эмчилгээний алгоритмыг тайлбарлана уу?

1. Хөхний эмнэлзүйн ба маммографийн шинжилгээ хийх
2. Хөхний эмнэлзүйн ба маммографийн шинжилгээнд арьс хавагнасан, улайсан бол мэргэжлийн эмчид заавал шилжүүлнэ.
3. Маммограм, хэт авиан шинжилгээнд гарсан өөрчлөлтийн дагуу зохих арга хэмжээг авна.
4. Туяа эмчилгээнд явуулах.
5. Хими эмчилгээнд явуулах.

/367./ Эмэгтэй хүн өөрөө хөхөө хэрхэн шалгах ёстой вэ?

1. Хөхөө харж шалгахдаа гэрэлтүүлэг сайтай өрөөнд нүцэглэн толины өмнө зогсоно.
2. Эхлээд гараа өргөж, дараа нь хоёр гараа толгой дээрээ өргөж зогсон хөхөө шалгана, дараа нь гараа ташаандаа авч зогсоод хөхөө харна.
3. Хөхөө харж шалгахдаа хоёр хөхний хэмжээ, хэлбэр, товчны байдал, хөхний арьсны байдал, суганы булчирхай харагдаж буй эсэхийг ажиглах ёстой.
4. Хөхийг тэмтэрч шалгахдаа эгэмнээс хөхний доод тал хүртэл, суганаас өвчүү хүртэл хөхийг бүхэлд нь, мөн эгэмний ба сугны булчирхайг шалгана. Хөхийг шалгахдаа 2,3,4-р хурууны алган талын гадаргуугаар босоо шугамаар, цацраг хэлбэрээр, эсвэл тойргоор тэмтэрч шалгаж болно.
5. Хөхний толгойг шахаж шалгах ба шүүрэл байгаа эсэхийг тогтоох.